# ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
# УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
# 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

***Тайлан хянасан:*** ***Төсвийн Төвлөрүүлэн захирагч***

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГА ............................................... / Э.БАТТУЛГА /
(албан тушаал) (гарын үсэг)

Тэмдэг ...............................
(огноо)

***Тайлагнасан:*** ***Төсвийн Шууд захирагч***

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН УС ЦАГ УУР,
ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ДАРГА ............................................... / С.АЛТАНДОЛГИОН /
(албан тушаал) (гарын үсэг)

Тэмдэг 2026.06.10
(огноо)

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | авч үйлчилсэн. | | ✓ Агаарын шинжилгээгээр уурын зуухтай байгууллагын тоос тоосонцрын агууламж MNS4585:2025 стандартаас 1.2-2.0 дахин давсан.<br>✓ Хаягдал усны химийн шинжилгээгээр Дархан төмөрлөгийн үйлдвэр ТӨХК, Элемент медикал ХХК-ийн үйлдвэрлэлийн хаягдал усны 3 үзүүлэлтийн бохирдлын агууламж MNS4943:2015 стандартаас 1.3-23 дахин давсан. Бусад сроьц, дээжүүдэд хийгдсэн шинжилгээгээр MNS стандартын зөвшөөрөгдөх хэмжээнд байна.<br>✓ Төвийн төрийн эрдэм шинжилгээ судалгааны байгууллагын үйлчилгээний ажлын орлого 5.6 сая төгрөг төвлөрүүлсэн.<br>Хэрэгжилт 100% | |

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ЕРӨНХИЙ ТЕХНОЛОГИЧ ИНЖЕНЕР Б.САЙНЖАРГАЛ

ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН М.АЛИМАА

## ДАРХАН-УУЛ АЙМГИЙН УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

### НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг | Төсөв /сая төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | **Зорилт 1.1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын бодлого зорилт** | | | | | | |
| | | 1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын 2025-2028 оны Стратеги төлөвлөгөө | | | | | | |
| 1 | 1.1 | БОШЛ-т цахим бүртгэл, мэдээллийн систем ашилах<br><br>(СТ-ний ҮАЧ-ийн зорилт 4-ийн 9 дэх арга хэмжээ) | Улсын төсөв | Хувь | Цахим бүртгэл хийгдээгүй | Ашиглалт 100% | 4 дүгээр сараас Байгаль орчны шинжилгээний сорьц бүртгэл, хяналтын dlab.weather.gov.mn систем нэвтрэх эрхээр бүртгэл хийх, шинжилгээний мэдээлэл оруулах, чанарын хяналт хийх, нягтлан бодогч санхүүгийн баталгаа хийх явцуудыг гүйцэтгэн усны химийн шинжилгээний дүнгээр үйлчилж, нэвтрүүлж эхэлсэн. “Элемент медикал” ХХК-ийн усны химийн шинжилгээний 1225 кодтой сорьцын бүртгэл, хяналт хийгдсэн. | 100% |
| 2 | 1.2 | Ус, цаг агаарын аюултай үзэгдлийн сэрэмжлүүлэг мэдээний чанарыг сайжруулах<br>(СТ-ний ҮАЧ-ийн зорилт 5-ын 9 дэх арга хэмжээ) | Улсын төсөв | Таарц, хувь | Онч 99.2% | Онч 99.3% | Урьдчилан мэдээлэх салбараас эхний 6 сарын байдлаар цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс сэрэмжлүүлэх 11 мэдээг зохиож таарц 100%-тай дүгнэгдсэн. Мэдээний таарц, чанар сайжирч зорилтот түвшин 0.7%-иар өссөн. | 100% |
| 3 | 1.3 | Гол мөрний дундаж урсац, үерийн урьдчилсан мэдээний таарцыг нэмэгдүүлэх<br><br>(СТ-ний ҮАЧ-ийн зорилт 5-ийн 11 дэх арга хэмжээ) | Улсын төсөв | Таарц, хувь | Үерийн мэдээ гаргаж байгаагүй | Үерийн мэдээний таарц 50% | 1. Байнгын ажиглалт, судалгаатай Хараа, Хүйтэн, Шарын голууд дээр 6 дугаар сарын эхэнд урсац 1.94-8.0м3/сек, усны түвшин олон жилийн дунджаас 36-54 см-ээр бага 175-201см байна. Одоогийн байдлаар усны түвшин үерийн хэмжээнд хүрээгүй тул урьдчилан мэдээ зохиох нөхцөл бүрдээгүй.<br>2. Шадар сайдын “Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийх” нэгдсэн удирдамжийн дагуу Ус судлалын салбараас аймгийн хэмжээнд 2026 оны хур борооны үерийн эрсдэлийн үнэлгээ хийсэн. Тооцооллоор индекс 4.2 буюу **“дунд эрсдэлтэй”** үнэлэгдэж эрсдлийг бууруулах зөвлөмжүүд гаргасан. Үнэлгээний тайланг боловсруулж баталгаажуулан аймгийн Онцгой комисс, Онцгой байдлыг газарт 2026 оны 6 дугаар сарын 08-нд хүргүүлсэн. | 100% |
| 4 | 1.4 | Хөдөө аж ахуйн цаг уурын урьдчилсан мэдээний таарцыг сайжруулах<br>(СТ-ний ҮАЧ-ийн зорилт 5-ийн 12 дахь арга хэмжээ) | Улсын төсөв | Таарц, хувь | Таарц 98.4% | Таарц 99.6% | Агро цаг уурын салбараас хавар хөрс гэсэх хугацааны урьдчилсан мэдээ зохиосон таарц 100%, хаврын хөрсний уггвар чийгийн мэдээний таарц 100%, улаанбуудайн бутлалтын үе шат илрэх хугацааны урьдчилсан мэдээний таарц 99.5%-иар үнэлэгдсэн. Урьдчилсан мэдээний чанар сайжирч зорилтот түвшин 0.2%-иар өссөн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2. Хүн төвт хөгжлийн төлөвлөгөө | | | | | |
| 5 | 2.1 | Цаг агаарын 5 хоногийн урьдчилсан мэдээний таарцыг сайжруулах<br>(ХТХ төлөвлөгөөний ҮАЧ-ийн 2.1) | Улсын төсөв | Таарц, хувь | Таарц 88.6% | Таарцыг 89.2% | Эхний хагас жилийн дүнгээр 5 хоногийн цаг агаарын урьдчилсан мэдээг 181 удаа зохиосон. Мэдээний таарц 88.6%-иар дүгнэгдэж зорилтот түвшинд хүрээгүй 0.6%-иар буурсан. Өвлийн саруудад агаарын температурын хэлбэлзэл их байснаас 10 удаа алдаж прогнозлосон нь таарц буурахад голлон нөлөөлсөн. | 0% |
| | | 3. “2026 оныг Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, технологи шинэчлэлийн жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ | | | | | |
| 6 | 3.1 | Ус цаг уур, орчны шинжилгээний салбарын ХАБЭА-н дүрэм, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааврыг хэрэгжүүлж ажиллах<br><br>*(ХААТШ-ийн төлөвлөгөөний 36 дахь арга хэмжээ)* | Улсын төсөв | Заавар, журам мөрдөх | Осол, зөрчилгүй ажилласан | Заавар мөрдөгдөж осол, зөрчилгүй ажиллах | 1. УЦУОШТ-ийн ХАБЭА-н ОТБЗ-ийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 5 зорилтын 18 арга хэмжээ төлөвлөснөөс 16 арга хэмжээний хэрэгжилт 100%-иар дүгнэгдсэн. Хугацаа болоогүй 2 арга хэмжээ байна.<br>2. ЦУОШГ-ын даргын 2026 оны А/43 тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “УЦУОШ-ний ажлын аюулгүй ажиллагааны дүрэм”, 2-11 дүгээр хавсралтаар батлагдсан Ус, цаг уур, орчны шинжилгээний салбаруудын “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны заавар”-ыг 7 салбарын 13 ажлын байрны 30 албан хаагчид календарьчилсан төлөвлөгөөний дагуу салбар хариуцсан инженерүүд зааварчилгааг өгч осол, аюулгүй ажиллаж байна.<br>3. Ажлын байрны галын аюулгүй байдлыг хангах чиглэлээр Төвийн болон Шаазгайт өртөөний галын булангийн иж бүрдэл, галын хор, галын гидрант, цахилгааны шит тус бүрт сар бүр хяналт тавьсан. Шаазгайт өртөөний байрны галын дүгнэлтийг сунгуулахаар бэлтгэл ажил хангаж байна.<br>4. Төвийн ХАБЭА-н ОТБЗөвлөлөөс аймгийн ҮЭХолбооны дэргэдэх ХАБЭА-н сургалтын төвтэй хамтран 8 цагийн сургалтыг батлагдсан хөтөлбөрийн дагуу зохион байгуулж ХАБЭА-н тухай хууль, дүрэм, журам, хамгаалах хувцас хэрэгсэл, аюулгүй ажиллагааны талаар заах ажилтан, албан хаагчдын чадавхжуулаа. Сургалтын төгсгөлд сорил шалгалт өгч 30 албан хаагч 80% аас дээш оноо авч тэнцсэн тул байгууллагад гэрчилгээ олгосон. Сургалтын зардал 1,050,000 төгрөгийг байгууллагын ҮЭХ-ноос гаргасан.<br>5. Аймгийн хэмжээнд “Ажлын байранд нийгмийн сэтгэл зүйн эрүүл орчныг бүрдүүлцгээе” уриатай аянд нэгдэж нийт албан хаагчдаас ажлын байрны сэтгэл зүйн 2 судалгаа явуулсан. Судалгаагаар албан хаагчдын 81% нь “Ажлын байранд бусдыгаа анхааралтай сонсох, шүүмжлэхээс өмнө бусдыгаа ойлгохыг хичээх, бие биедээ итгэх чадвартай” гэсэн дүгнэлт гарсан. | 100% |
| 7 | 3.2 | Хэвийн бус нөхцөлд ажилладаг БОШЛ-ийн албан хаагчдыг өвөрмөц шинжилгээнд хамруулах | Улсын төсөв | Тоо, хувь | Шинжил-гээнд хамрагдсан. | Шинжилгээнд хамруулах | ЭМСайдын 2014 оны А/340 дүгээр тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгийн журам”-ын 2 дугаар хавсралтын дагуу Саруул мед клиниктэй гэрээ байгуулж төсвийн 840,000 төгрөгний зардлаар БОШЛ-ийн 3 инженерийг эрүүл мэндийн өвөрмөц шинжилгээнд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | *(ХААТШ-ийн төлөвлөгөөний 39 дэх арга хэмжээ)* | | | | | хамруулсан. Өмнө жилийн шинжилгээний дүнтэй харьцуулахад химийн бодисын хортой нөхцөлөөс хамаарсан сөрөг нөлөөлөл бага, эрдэсийн дутагдал илүү илэрсэн. | |
| 8 | 3.3 | БОШЛ-ийн албан хаагчдыг шинжилгээ хийхэд хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах *(ХААТШ-ийн төлөвлөгөөний 40 дэх арга хэмжээ)* | Улсын төсөв | Тоо, хувь | Төсөв батлаг-даагүй. | Төсөвт багтааж олгох | 1. Төсвийн 1.125.000 төгрөгний зардлаар хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилладаг БОШЛ, Дархан-Бороо экспедицийн ажилтануудыг ажлын хувцас, хамгаалах хэрэгсэлээр хангасан.<br>2. 4 дүгээр сард салбаруудын хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгсэлийн судалгааг шинэчилж, 2027 оны төсвийн төсөл, төсөөлөлд 2.7 сая төгрөг, нормын хувцас зөөлөн эдлэлийн зардалд 6.1 сая төгрөгийг тусгасан. | 100% |
| 9 | 3.4 | БОШЛ-ийн албан хаагчдыг шинжилгээ хийхэд хор саармагжуулах бүтээгдэхүүн олгож эрүүл мэндийг хамгаалах<br><br>*(ХААТШ-ийн төлөвлөгөөний 41 дэх арга хэмжээ)* | Улсын төсөв | Тоо, хувь | 890.400 төгрөгний бүтээг-дэхүүн олгосон. | Төсөвт багтааж олгох | 1. ЭМСайдын 2000 оны А/171 дүгээр тушаалын дагуу БОШЛ-ийн албан хаагчдын 2026 онд шинжилгээ хийх хуваарь, олгох хор саармагжуулах бүтээгдэхүүний тоо хэмжээг сар, жилээр гаргаж тооцсон жагсаалтыг санхүү хянаж төвийн дарга баталсан.<br>2. БОШЛ-ийн 3 албан хаагчдын 4-8 сард хэрэглэх хор саармагжуулах бүтээгдэхүүний зардалд төсвөөс 560.000 төгрөг зарцуулсан. | 100% |
| | | **Зорилт 1.2. Аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.11.1. “Агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх** | | | | | | |
| 10 | 1.2.1. | Агаарын бохирдлын эх үүсвэрийн тооллогыг сумдын ЗДТГ-тай хамтран зохион байгуулах, холбогдох зардлыг шийдвэрлэх<br><br>/ЗДҮАХ-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 3.11.1-д тусгасан арга хэмжээ/ | - | Тоо бүртгэл | 2024 оны тооллого, бүртгэл хийгдэж тайлаг-насан. | 2025 оны тооллого, бүртгэл хийгдэж тайлагнах | Аймгийн Засаг даргын 2026 оны 01-А/16 захирамжаар Дархан-Уул аймгийн агаарын бохирдлын эх үүсвэрийн тоо бүртгэлийг явуулах ажлын хэсэг байгуулагдаж тооллого зохион байгуулсан. Тооллогын үр дүн:<br>1. 3-15кВт хүртэл хүчин чадалтай зуух аймгийн хэмжээнд 7557 тоологдож өмнөх оны тооллогын дүнтэй харьцуулахад 378-аар буурсан, суурьшлийн хамгийн том бүс Дархан суманд 6109 зуух тоологдож өмнөх оноос 416-аар буурсан.<br>2. 15-100кВт хүртэл хүчин чадалтай 30 зуух тоологдож өмнөх оноос 3-аар нэмэгдсэн.<br>3. 100-4200кВт хүртэл хүчин чадалтай 12 ААНБ-ын 19 зуухны 17 яндан тоологдож 10184.8 тн нүүрс хэрэглэсэн байна. 2024 оны тооллогын дүнтэй харьцуулахад зуух 3 -аар буурсан.<br>4. 4200кВт-аас дээш хүчин чадалтай зуухтай 2 ААНБ 606086 тн нүүрс хэрэглэсэн нь өмнөх оноос 9684 тн-оор илүү түлш хэрэглэсэн байна.<br>5. Хөдөлгөөнт эх үүсвэрийн тооллогоор аймгийн хэмжээнд 31562 тээврийн хэрэгсэл тоологдож өмнөх оноос 16% нэмэгдсэн. Нийт тээврийн хэрэгслийн 83% нь 10 ба түүнээс дээш жилийн насжилттай ч өмнөх оноос 5% буурчээ.<br>6. 2025 оны тооллогын дүнг төрөл ангиллаар бүртгэлжүүлэн “Орчны бохирдлын эх үүсвэр, хаягдлын тооллогын мэдээллийн сан”-г бүрдүүлж, агаарт хаягдах хорт хий болон | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тоос, тоосонцрын хаягдлын ялгарлыг тооцох, ашиглах суурь мэдээллийг бүрдүүлсэн.<br>7. Аймгийн 2025 оны тооллого бүртгэлийн дүн мэдээ, дүгнэлт, 5 саналтай тайланг 03 дугаар сарын 10-нд ажлын хэсгийн хуралд танилцуулж албажуулан аймгийн Дархан хотын захирагчийн зөвлөх, ажлын хэсгийн дарга Я.Бат-Очирт хүлээлгэн өгсөн. Мөн тайланг ЦУОШГ-ын мэргэжилтэн, аймгийн БОГ, аймаг, сумдын ЗДТГазарт хүргүүлсэн. | |
| 11 | 1.2.2 | Агаарын чанарын автомат станцын тасралтгүй ажиллагааг хангах<br><br>/ЗДҮАХ-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 3.11.4-д тусгасан арга хэмжээ/ | - | Агаарын чанарын үнэлгээ | Тасралтгүй хэмжилт хийгдсэн | 6 үзүүлэлтээр хэмжилт хийгдэх | Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 3.11.4, аймгийн "Агаарын бохирдлыг бууруулах" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 3.5.1, Засаг дарга БОУАӨСайдтай 2026 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний 3.6-д Дархан сумын агаарын чанарын автомат станцын тасралтгүй ажиллагааг хангах арга хэмжээ тусгагдсан тул шаардлагатай зардлыг 2027 оны аймаг, орон нутгийн төсвийн төсөл тусгуулна. Орон нутгийн төсөвт санал авах хуулийн хугацаа жил бүрийн 7-8 дугаар сар тул хугацаа болоогүй. | - |
| 12 | 1.2.3. | Дархан сумын 1-3 дугаар багийн орчинд PM10 тоосонцор хэмжигч багаж суурилуулж, агаарын чанарыг үнэлэх | ОНХО 142.0 | Хэмжилтийн тоо | Тоосонцорын агууламж стандартаас 3-4 дахин их гардаг. | Тоосонцрыг тодорхойлж, агаарын чанарыг тогтмол үнэлэх | Аймгийн Засаг даргын 2026-2028 оны үйл ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 3.11.1, аймгийн "Агаарын бохирдлыг бууруулах" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.5.2-д тусгагдсан Дархан сумын 1-3 дугаар багийн орчинд агаар дахь PM10 тоосонцрыг хэмжиж, бохирдлыг бууруулах арга хэмжээний хүрээнд тоосны багажаар авах зардлыг 2027 оны аймаг, орон нутгийн төсвийн төсөлд тусгана. Орон нутгийн төсөвт санал авах хуулийн хугацаа жил бүрийн 7-8 дугаар сар тул хугацаа болоогүй. | - |

**ХОЁР. НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ**

| Д/д | | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| Зорилт 2.1. Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.1.1, 4.4.1.3-т тусгагдсан Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна, 4.5.1.1,4.5.1.3 дахь арга хэмжээ Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх | | | | | | | | |
| 13 | 2.1 | Төвийн 2026-2028 оны стратегийн хөтөлбөр, төлөвлөгөөг батлуулах | - | Тоо, хувь | 2021-2024 оны СТ 95% | Стратеги төлөвлөгөөг батлуулах | Төвийн 2026-2028 оны стратегийн хөтөлбөр, төлөвлөгөөг 3 үндсэн чиг үүрэгт хамаарах 9 дэд чиг үүрэгт 31 арга хэмжээ төлөвлөж 2026 оны 4 дүгээр сард аймгийн Засаг даргаар батлуулсан. | 100% |
| 14 | 2.2 | Төвийн 2026 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөө баталж сургалт зохион байгуулж | Улсын төсөв | Тоо, чанар | Мэргэшүүлэх 9 сургалт хийгдсэн | Төлөвлөгөөний дагуу сургалт-ууд хийх | УЦУОШТ-өөс хийгдсэн сургалтууд:<br>1. 2026 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу 3-4 дүгээр сард "Цаг уурын ажиглалтын стандарт ба технологи", "Итгэмжлэлийн MNS IS0/IEC17025.2018 стандартын үйл | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | албан хаагчдыг чадавх-жуулах | | | | | явцын 11 шаардлагыг хангах" "Усны салбарын бодлого, зорилт хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа" сэдэвт 3 удаагийн 12 цагийн сургалтад 17 албан хаагч ;<br>2. АҮЭХолбооны дэргэдэх ХАБЭА-н сургалтын төвтэй хамтран 8 цагийн сургалтад 31 албан хаагч ;<br>3. Төрийн албаны зөвлөлийн Дархан-Уул аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлтэй хамтран "Төрийн албан хаагчийн ёс зүй" 16 цагийн сургалтад 32 албан хаагч;<br>4. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай цахим сургалтад 31 албан хаагч;<br>6 төрлийн сургалтад 111 албан хаагч оролцсон. Төвийн сургалт 100% хийгдсэн.<br><u>ЦУОШГ-аас хийгдсэн сургалтууд</u>:<br>1. ЦАЗН ажилтаны эрх олох сургалт, Нислэгт цаг агаарын урьдчилсан мэдээгээр үйлчлэх танхимаар хийгдсэн 2 сургалтад 2 албан хаагч;<br>2. Агаарын чанарын MASIM программын сургалт, АЧ-ын багаж төхөөрөмжтэй ажиллах 2 удаагийн цахим сургалтад 6 албан хаагч хамрагдсан.<br>3. Зарим цахим сургалтууд удирдлагын хүрээнд хийгдсэн байна.<br>Эхний хагас жилийн байдлаар нийт 11 төрлийн сургалтад 120 албан хаагч хамрагдаж УЦУОШТ-ийн сургалтууд төлөвлөлтийн дагуу 100% хийгдэж албан хаагчид мэргэжлийн ур чадвар дээшилсэн. | |
| 15 | 2.3 | УЦУОШ-ний салбарын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн дагуу 2026 оны төлөвлөгөө баталж хэрэгжүүлэх | Улсын төсөв | Тоо, чанар | 95%-тай хэрэгжсэн. | Хөтөлбөр-ийг хэрэгжүүлэх | ЦУОШГ-ын 2025 оны А/147 дугаар тушаалаар батлагдсан 2025-2029 оны Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 6 зорилтын хүрээнд тус төвийн 2026 оны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллалаа<br>1. ХАБЭА-н чиглэлээр байгууллагын үйл ажиллагаанд мөрдүүлэх дүрэм, зааврыг нийт ажилтнуудад танилцуулж, сургалт зохион байгуулан мэдлэг ойлголтыг нэмэгдүүлсэн. Ажилтнуудын цалин хөлс, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал, шөнийн ажлын нэмэгдэл, илүү цаг болон нийтээр амрах баярын өдрийн нэмэгдлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүрэн тооцож олгосон. Мөн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хүрээнд 32 албан хаагчид 41.9 сая төгрөгийн урамшууллыг олгож ажилласан.<br>2. Хүний нөөцийн хөгжлийг дэмжих чиглэлээр албан тушаалын шаардлага хангасан 2 албан хаагчийг шатлан дэвшүүлж, инженер техникийн нийт ажилтнуудаас мэргэшлийн зэрэгтэй 5 албан хаагчид холбогдох нэмэгдлийг олгосон. Төрийн албан хаагчдад зориулсан мэргэжлийн болон зорилтот сургалтуудад ажилтнуудыг хамруулж, цаг уурын мэргэжлээр | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | суралцаж буй албан хаагчдад сургалтын төлөвлөгөөний дагуу дэмжлэг үзүүлэн ажилласан.<br>3. Ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах, эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх зорилгоор аймгийн БТСГазартай хамтран ажиллаж, бие бялдрын хөгжлийн түвшин тогтоох сорил, эрүүл мэндийн сургалт, зөвлөгөө, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулсан. Мөн хөдөлмөрийн нөхцөлөөс шалтгаалах эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд ажилтнуудыг хамруулж, ажилтнуудын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд анхааран ажилласан.<br>4. Дэлхийн цаг уурын өдрийг тохиолдуулан аймгийн хэмжээнд reel бичлэгийн уралдаан, мэргэжил сурталчлах арга хэмжээ, спортын тэмцээн уралдааг зохион байгуулж, байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчилж дэлгэрэнгүй тайланг ЦУОШГ-т хүргүүлсэн. | |
| 16 | 2.4 | Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгээр илэрсэн зөрчлийг арилгах, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах | Улсын төсөв | Тоо, чанар | Хангалттай үнэлэгдсэн, зөвлөмж хэрэгжүүлэх | Зөвлөмжийг хэрэгжүүлж зөрчлийг арилгах | 1. Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн өгсөн зөвлөмжийн дагуу сэлбэн засах шаардлагатай байнга хадгалах 2022-2023 оны 22 баримт, 2019-2022 оны түр хадгалах 54 баримтын баталгааны хуудас, дотоод товъёогны гарын үсэг, цагаан цаасаар үдсэн баримтыг бор хавтасаар үдэж сэргээн засварлах ажил 100% хийгдсэн.<br>2. Байгууллагын архив, шинжилгээний архивтай хамт нэг өрөөнд байсан тул "Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам"-ын 6.4-т "Архив нь зориулалтын өрөө тасалгаатай байна" гэж заасны дагуу урьдчилан мэдээлэх салбарын 35 м2 талбайтай том өрөөг вакум хаалтаар тусгаарлаж шинжилгээний архивын өрөө үүсгэж стандартад нийцүүлсэн. | 100% |
| 17 | 2.5 | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай биелүүлэх, албан бичиг, өргөдөл, гомдлыг хугацаанд нь шийдвэрлэж, тайлагнах | УТ | Тоо, хувь | 100% хэрэгжсэн. | Хэрэгжэгтийг хангах | 2026 оны эхний хагас жилийн байдлаар байгууллагын үйл ажиллагаатай холбоотой гомдол, санал ирээгүй. Сумын цаг уурын өртөө, харуулын 2 ажилтны жирэмсэний амралттай хугацаанд 2 иргэнээс ажиллах хүсэлт ирсэнийг журмын дагуу шийдвэрлэсэн. Албан хаагчдаас ирсэн 5 хүсэлтийг Хөдөлмөрийн тухай хууль, байгууллагын дотоод хэм хэмжээг үндэслэн 100% шийдвэрлэсэн. Өргөдөл, гомдлын I улирлын мэдээ тайланг аймгийн ЗДТГ-ын ТЗУХэлтэст хугацаанд нь тайлагнасан. | 100% |
| 18 | 2.6 | Байгууллагын мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангаж shilen.gov.mn сайтад мэдээ, мэдээлэл байршуулах | - | Үнэлгээний увь | shilen.gov.mn 84 оноогоор үнэлэгдсэн. | Мэдээ мэдээллийг байршуулах 90% | "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам"-ын дагуу www.shilen.gov.mn цахим мэдээллийн сайтад 5 төрлийн 20 мэдээлэл байршуулж 2026 оны 1 дүгээр улиралд 86.2%-тай дүгнэгдсэн. 2 дугаар улиралд үнэлгээг 90%-д хүргэнэ. | 33% |
| 19 | 2.7 | Төсөв, санхүүгийн сахилга батыг сахиж, зардлын ангиллаар зориулалтын | Улсын төсөв | Тоо, хувь | Зөрчилгүй ажилласан | Төсвийг үр дүнтэй | 1. 2026 оны батлагдсан 1,340.2 сая төгрөгийн төсвийн хүрээнд өр төлбөр үүсгэлгүй ажиллаж байна. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | дагуу үр ашигтай зарцуулах, шилэн дансаар мэдээлж ил тод байдлыг хангах | | | | зарцуулах, шилэн дансаар мэдээлэх | - 2025 оны үйл ажиллагааны давсан орлого 30,468,900 төгрөгнөөс 2025 оны жилийн эцсээр 4,985.7 мянган төгрөг, 2026 оны 1-3 сарын гүйцэтгэлээр үүссэн байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын 6,000.0 мянган төгрөг нийт 10,985.8 мянган төгрөгний өр төлбөрийг барагдуулж төлбөрийг барагдуулсан. Давсан орлогын үлдэдэл 20,468,900 төгрөгийн Сангийн сайдын баталсан журмын дагуу байгууллагын үйл ажиллагаанд дутагдаж байгаа зардалд зарцуулсан.<br>- Төвийн даргын 2026 оны 03 дугаар сарын 12-ны 44 дугаартай албан бичгээр 4 дүгээр сарын төсвийн хуваарьт 11,846.4 мянган төгрөгийг урагшлуулж зохицуулахаар санал хүргүүлсэн. 2026 оны 5 дугаар сарын 20-нд 10,923.0 мянган төгрөгийн төсвийг урагшлуулах, 12,489.4 мянган төгрөгийн төсвийг зохицуулах саналыг боловсруулж ЦУОШГ-ын Төсвийн мэргэжилтэнд google drive системээр хүргүүлсэн.<br>2. 5 дугаар сарын өссөн дүнгээр батлагдсан төсвөөс цалин хөлсний зардалд 384.9 сая, НДШ-ийн зардалд 50.8 сая, бусад урсгал зардалд 7.9 сая төгрөг, нэмэлт санхүүжилтээс орон нутгийн нэмэгдэл цалин хөлсний зардалд 82.4 сая, НДШ-ийн зардалд 10.4 сая, бусад зардалд 29.6 сая төгрөгийг холбогдох зардлын ангиллаас зарцуулсан.<br>3. Эхний хагас жилийн байдлаар үйл ажиллагааны орлого 6,313.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн.<br>4. Нягтлан бодох бүртгэлийг анхан шатны хүчин төгөлдөр баримтыг үндэслэн хөтөлж, тайлан мэдээг хуулийн хугацаанд бэлтгэн тайлагнасан. НДШ-ийн тайлан 6, төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, өглөг авлагын мэдээг сар бүрийн эхэнд 6 удаа, цалин хөлсний тооцоог 12 удаа бэлтгэсэн.<br>5. Төвийн даргын 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 30 дугаартай албан бичгээр 25.2 сая төгрөгийн хөрөнгийг дахин үнэлэх, 23.6 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хасах саналыг ЦУОШГ-т хүргүүлсэн.<br>6. Төрийн болон орон нутгийн өмчийн цахим мэдээллийн систем (umch.sgov.mn)-д санхүүгийн тайлан, хөрөнгийн эхний үлдэгдэл, хөдлөл өөрчлөлтийг шинэчилсэн системд бүрэн татаж санхүүгийн тайлангийн тулгалт хийж баталгаажуулсан. 2026 оны 5 дугаар сард ТӨБЗГ-ын ажлын хэсэгт 2025 оны тайлан мэдээг шалгуулж, өмч эзэмшүүлэх гэрээг 91%-тай дүгнүүлсэн.<br>7. 2026 оны эхний хагас жилд Шилэн дансны тухай хуульд заасан 81 мэдээллийг shilendans.gov.mn сайтад хугацаанд нь тайлагнаж, санхүүгийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлын хангаж ажилласан. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 20 | 2.8 | ТАХ-ийн ёс зүйн тухай хууль, авлига, ашиг, сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх суралт, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлан хэрэгжүүлж ажиллах | Улсын төсөв | Тоо, хувь | Төлөвлөгөө 100% хэрэгжсэн. | Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх | УЦУОШТ-ийн даргын 2026 оны А/02 тушаалаар төвийн Ёс зүйн дэд хороог шинэчлэн баталсан. УЦУОШТ-ийн ёс зүйн дэд хорооны 2026 оны ажлын 3 зорилтын 20 арга хэмжээний төлөвлөгөө батлуулах, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>1. 2026 оны 04 дүгээр сарын 27, 28-нд Төрийн албаны зөвлөлийн Дархан-Уул аймаг дахь салбар зөвлөлтэй хамтран "Төрийн албан хаагчийн ёс зүй" 16 цагийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтанд нийт албан хаагчид 100% хамрагдаж, төрийн албан хаагчийн ёс зүйн үзэл баримтлал, төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, тогтоомжийн талаарх мэдлэгээ ахиулж, ёс зүйн хэм хэмжээг сахин мөрдөж, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллах талаар мэдлэг, мэдээлэл авсан.<br>2. ТАХ-ийн ёс зүй, харилцаа, хандлагын судалгаагаар албан хаагчдын 86% сэтгэл зүйн толерант чадвар “Дунд” үнэлэгдсэн нь ажлын байранд бусдынхаа үзэл бодол, зан төлөв, алдаа дутагдлыг нь хүндэтгэн ойлгож, тайван хүлээцтэй хандах чадвараа нэмэгдүүлэхэд анхаарах шаардлагатайг харуулсан.<br>3. Төвийн УЦУОШТ-Ёс зүйн дэд хороо пэйж-ээр ТАХ-ийн ёс зүйтэй холбоотой 6 мэдээллийг байршуулж, танилцуулсан. | 100% |
| 21 | 2.9 | Төвийн хүний нөөцийн ил тод шударга байдлыг хангах, шударга байдал, сэтгэл ханамжийн судалгаа авах, хэрэгжүүлэх | - | Тоо, чанар | Сонгон шалгауур-лалт 2 удаа хийгдсэн, судалгаа авсан. | Ил тод нээлттэй шударга ажиллах, судалгааны үр дүн | 1. Ажилтнуудын сэтгэл ханамж, шударга байдлын түвшинг үнэлэх зорилгоор санал асуулгыг тогтмол зохион байгуулж, үр дүнд үндэслэн тулгамдсан асуудлыг тодорхойлон сайжруулах арга хэмжээг төлөвлөсөн.<br>2. Байгууллагын дотоод хэм хэмжээнд ажлын байрны ялгаварлан гадуурхалт, дарамт, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжиж буй төслийн хүрээнд байгууллагын ажилтнуудыг судалгаа, сургалт, зөвлөн туслах үйл ажиллагаанд хамруулж, аюулгүй, эрх тэгш, хүндэтгэлтэй ажлын орчныг бүрдүүлэх чиглэлээр ажиллаж байна.<br>3. Албан хаагчдын хөдөлмөрлөх эрх, нийгмийн баталгаа, ажиллах нөхцөл, эрүүл мэнд, мэргэжлийн хөгжил, байгууллагын соёлыг дэмжих чиглэлээр төлөвлөсөн арга хэмжээнүүдийг үе шаттай хэрэгжүүлж, ажилтны сэтгэл ханамж, бүтээмж, байгууллагын үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэхэд ахиц гаргасан. | 100% |
| 22 | 2.10 | Тэрбум мод үндэсний хөдөлгөөнд нэгдэж мод тарих | - | Тоо, ургалтын хувь | 200ш мод тарьсан | 200ш мод тарьж ургуулах | 5 дугаар сарын 12-нд Дархан-Уул аймаг Дархан сумын Морин хуур цогцолборын зүүн талд байрлах "Шинэ иргэний төгөлд" 32 ажилтан 65 ширхэг агч мод тарьсан. Модны арчилгаа, усалгааг нэгдсэн байдлаар аймгийн Нийтийн аж ахуйн үйлчилгээний газар хийхээр болсон. Сүүлийн хагас жилд үлдсэн модоо тарихаар төлөвөсөн | 100% |

## ГУРАВ. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ:

| Д/д | | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **Зорилт 3.** Хөтөлбөр батлах тухай ЦУОШГ-ын даргын 2016 оны А/02, 2020 оны А/75 тушаалын дагуу шинжилгээ, мэдээлэл, үйлчилгээний ажлын хөтөлбөрийн хэрэгжүүлж улсын сүлжээний нэгжийн тасралтгүй байдлыг хангах, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангах, шинжилгээ, судалгааны ажил хийх | | | | | | | | |
| | | **3.1. Цаг уурын шинжилгээний ажлын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах** | | | | | | |
| 23 | 3.1.1 | Цаг уурын шинжилгээний ажлыг хөтөлбөрийн дагуу хэмжилт хийх | Улсын төсөв | Тоо, хувь | 7670 ажиглалт 100% хийгдсэн | 7850 ажиглалтыг 100% хийх | Цаг уурын 2 өртөө, ХАА-н цаг уурын 2 харуулууд хөтөлбөрийн дагуу цаг уурын ажиглалтыг 3925 удаа хийсэн. Эхний 5 сарын байдлаар шинжилгээний ажлын хөтөлбөрийг 100%-тай хэрэгжүүлсэн | 100% |
| 24 | 3.1.2 | Нарны цацраг судлалын AWS 310R автомат станц хэмжилт хийх | Улсын төсөв | Тоо, хувь | 8760 хэмжилт 100% хийгдсэн | 8760 хэмжилт 100% хийх | Дархан өртөөний нарны автомат станц тасралтгүй ажиллаж 4380 удаагийн хэмжилт хийгдэж шинжилгээний ажлын хөтөлбөрийг 100% хэрэгжүүлсэн. | 100% |
| 25 | 3.1.3 | Цацрагийн 2 түвшний хэмжилт хийх | Улсын төсөв | Тоо, хувь | 1420 хэмжилт 100% хийгдсэн | 1420 хэмжилт 100% хийх | Цаг уурын 2 өртөө агаар, хөрсөнд цацрагийн түвшинг 730 удаа хэмжиж мэдээллийг eic.mn сайтад админ эрхээр шивж 100% оруулсан. | 100% |
| 26 | 3.1.4 | Мэдээ дамжуулалтын хяналтын системээр хугацааны мэдээ 7850 климат 36, агро дундаж 36 нийт 7922 мэдээг шуурхай дамжуулах | Улсын төсөв | Тоо, ирцийн хувь | 7922 мэдээний ирц 100% | 7922 мэдээний ирц 100% | 1. Цаг уурын өртөө, харуулууд ажиглалтын 3925 мэдээнээс тасарсан мэдээ байхгүй, 8 мэдээг хяналтын хугацаанаас 1-8 хүртэл минутаар хоцроож дамжуулсан. Хугацаа хоцроосон мэдээний тоог 2025 оны мөн үетэй харьцуулахад ижил түвшинд байна.<br>2. Өртөө, харуулууд 10 хоногийн климатыг 72, сарын климатыг 24 удаа зохиож мэдээг 100% дамжуулсан.<br>3. Аюул мэдээ 48, давтан аюул 2, агаар мэдээ 48 нийт 98 мэдээг 100%-ийн чанартай дамжуулсан. | 100% |
| 27 | 3.1.5 | Цаг уур, нарны цацраг судлалын шинжилгээний ажлын шүүмж шалгалтын чанар | Улсын төсөв | Тоо, хувь | Цаг уурын шалгалтын дүн 99.4% Нарны цацраг судлалын шалгалтын дүн 99.6 % | Цаг уурын шалгалтын дүн 99.5% Нарны цацраг судлалын шалгалтын дүн 99.7% | 1. 2025 оны 12 сар, 2026 оны эхний 5 сарын Цаг уурын 2 өртөө, ХАА-н цаг уурын 2 харуулын 24 тайланд цаг уурын инженер шүүмж шалгалт хийж УЦУОСМХ-ийн УАӨНСХэлтэст цахимаар илгээсэн. Хэлтсээс ирүүлсэн зааварчилгаанд Шарын гол харуулын ажиглагч үүл, үзэгдэлийн уялдаанд анхаарах, Хонгор харуулын агаарын харьцангуй чийг, температур хэмжигч автомат төхөөрөмж (HUAYUN) -ийн чийг өндөр зааж мэдрүүр гэмтэлтэй зэргээс ажиглалтын чанар буурч 99.1%, шүүмжийн чанар 99.1%-иар дүгнэгдсэн. Зорилтот түвшингөөс 0.4%-иар буурсан.<br>2. Нарны цацраг судлалын тайлангийн шүүмж шалгалт хийж УЦУОСМХ-ийн УАӨНСХэлтэст хугацаанд нь илгээсэн. Ажиглалтын чанар 100%-иар дүгнэгдэж зорилтот түвшингөөс +0.3% ахисан байна. | 50% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Цаг уур 0% Нар 100% дунджаар 50% үнэлэв. | |
| | | **3.2. Цаг агаарын урьдчилсан мэдээний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах** | | | | | | |
| 28 | 3.2.1 | Цаг агаарын 3 төрлийн урьдчилсан мэдээг өдөр бүр зохиох, дамжуулах | Улсын төсөв | Тоо, хувь | Нийт ирц 99.9%, НМ 365 дүн 96.8%, 1 хоногийн мэдээний дүн 94.5%, 5 хоногийн мэдээний дүн 88.6%, нэгдсэн дүн 95.9% | Нийт ирц 100%, НМ-ний дүн 96.9% 1 хоногийн мэдээний дүн 94.6%, 5 хоногийн мэдээний дүн 89.2%, нэгдсэн дүн 96.0% | Урьдчилан мэдээлэх салбараас цаг агаарын 3 төрлийн урьдчилсан мэдээг нийт 543 удаа зохиож 100% дамжуулсан. Эхний хагас жилийн нэгдсэн дүнгээр:<br>1. Нарийвчилсан мэдээний таарц 97.3%-тай<br>2. Хоногийн мэдээний таарц 93.4%-тай<br>3. 5 хоногийн мэдээний таарц 87.0%-тай дүгнэгдсэн.<br>4. 543 мэдээний ирц 100% -тай дүгнэгдсэн.<br>Эхний хагас жилийн нэгдсэн дүнгээр 95.5%-тай дүгнэгдэж зорилтот түвшинд хүрээгүй 0.5% -иар буурсан. **Таарц буурсан шалтгаан:** 12 дугаар сард агаарын температурын хэлбэлзэл их байсан учир нийт зохиосон мэдээний 54%-д нь дулааруулж, хүйтрүүлж прогнозлосноос таарц буурсан. | 0% |
| 29 | 3.2.2 | Цаг агаарын аюултай үзэгдлээс сэрэмжлүүлэх, гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээг зохиох, дамжуулах | Улсын төсөв | Тоо, хувь | СМ-14, УСМ-1 мэдээний таарц 99.0% | Нөхцөл бүрдсэн үед СМ, УСМ мэдээний таарц 99.1% | Урьдчилан мэдээлэх салбараас эхний 6 сарын байдлаар цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс сэрэмжлүүлэх мэдээ 11, анхааруулга мэдээ 61 нийт 72 мэдээг зохиож үйлчилсэнээс мэдээний илүүлэлт, онч, таарц 100% -иар дүгнэгдэж зорилтот түвшингээс 0.9%-иар өссөн. Урьдчилан сэргийлэх мэдээ зохиох нөхцөл бүрдээгүй, хуурамч түгшүүр болон өгөөгүй ажиглагдах үзэгдлийн тохиолдол гаргаагүй. | 100% |
| 30 | 3.2.3 | Нам өндрийн нислэгт цаг агаарын урьдчилсан мэдээгээр үйлчлэх | Улсын төсөв | Тоо, хувь | 13 нислэгт 67 мэдээгээр үйлчилсэн дүн 99.1% | Нислэгийн төлөвлөгөө-ний дагуу үйлчлэх, дүн 99.2% | Эхний 6 сарын байдлаар төлөвлөгөөт нам өндрийн нислэгт доорх мэдээгээр үйлчилсэн.<br>✓ Нислэгийн тоо -13<br>✓ Чиглэлийн урьдчилсан мэдээ /НИ-5/ - 10<br>✓ TOIM TAF - 18<br>✓ Районы мэдээ -18 нийт 59 мэдээ зохиож нислэгийн шуурхай байдлыг хангаж ажилласан. Тайланг сар бүрийн 02-нд amc@namem.gov.mn цахим шуудангаар 5 удаа илгээсэн. Дээрх 59 мэдээг MDS цахим хаягаар 100% дамжуулсан. Нэгдсэн дүнгээр 99.96%-иар дүгнэгдэж зорилтот түвшингээс 0.9%-иар өссөн. | 100% |
| | | **3.3. Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх ажлын хэрэгжилтийг хангах** | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 31 | 3.3.1 | Дархан бороо экспедицийн үйл ажиллагааг зохион байгуулах, бэлтгэл хангах | Улсын төсөв | Тоо, хувь | Бэлтгэл 100% хангаж ажилласан | Бэлтгэл 100% хангах | 1. ЦУОШГ-ын даргын 2026 оны А/57 тушаалаар ЦАЗН үйл ажиллагааг эхлүүлэх тухай тушаалыг үндэслэн төвийн даргын 2026 оны Б/19 тушаалаар Дархан-Бороо экспедицийн бүрэлдэхүүн, ажиллах чиг үүргийг баталсан.<br>2. Аймгийн ИТХ-ын дэргэдэх Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлөөс Дархан-Бороо экспедицийн 2026 оны үйл ажиллагаанд шаардлагатай шатахуун, гэнэтийн ослын даатгал, интернэтийн үйлчилгээ, хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгсэл, автомашины сэлбэг хэрэгсэл, GPS төхөөрөмжийн зардалд нийт 3,589,596 төгрөгний санхүүжилт шийдвэрүүлсэн.<br>3. Экспедиц хээр байрлаж ажиллах харвалтын цэгүүдийн маршрут, замын схем зургийг боловсруулж, аймгийн Цагдаагийн газрын даргаар батлуулсан.<br>4. Хээрийн ажиллагаанд гарахын өмнө төвийн багажийн инженер агаарын температур, чийг хэмжигч HUAYAN төхөөрөмж, агаарын даралт хэмжигч анероид барометрийн ажиллагааг харьцуулсан тоолол хийж ажилд тэнцсэн тухай хэмжих хэрэгслийн шалгалт тохируулгын хуудас олгосон.<br>5. ЦАЗН-ийн иженер, техникийн ажилтангууд пуужин харвах төхөөрөмж болон суурьт үзлэг, засвар, цэвэрлэгээ үйлчилгээ хийсэн. Галын 2 хорны ажиллагааг шалгаж автомашинд суурилуулсан.<br>Бэлтгэл 100% хангагдаж зорилтот түвшинд хүрсэн. | 100% |
| 32 | 3.3.2 | Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлж ой хээрийн түймэр гарах нөхцлийг бууруулах, хөсний чийгийн хангамжийг сайжруулах | Улсын төсөв | Тоо, хувь | 10 мм тунадас нэмэгдүүл-сэн ажлын дүн 99.5% | 12 мм тунадас нэмэгдүүлэх ажлын дүн 99.7% | 1. Дархан-Бороо экспедиц нь 2025 оны үлдэгдэл 15 пуужин, 2026 онд ЦУОШГ-аас 20 пуужин нэмж нийт 35 пуужинтай үйл ажиллагааг эхлүүлсэн.<br>2. 5 дугаар сарын агаарын температур сэрүүн байгаатай холбоотой хуурайшлын зэрэг дунджаар 3051.9 гарсан бөгөөд өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад 2886.4 бага байна.<br>3. 04 дүгээр сарын 26-ны өдөр баруун хойдын процесст бороонды 3 пуужин харваж нөлөөлсөнөөр нийт нутгаар 1.7-6.8мм бороо орж тунадас нэмэгдүүлэх ажиллагааг явуулсан. Үр дүнгийн тооцоогоор аймгийн хэмжээнд 1.9мм тунадас нэмэгдүүлсэн.<br>4. 05 дугаар сарын 21-ний өдөр баруун өмнийн процесст бороонды 3ш пуужин харваж тунадас нэмэгдүүлэх ажиллагаа явуулж нийт нутгаар 2.4-3.7мм бороо орсон. Үр дүнгийн тооцоогоор 1.2мм | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тунадас нэмэгдүүлсэн. Дээрх 2 удаагийн ажиллагааны үр дүнд нийт нутгаар 3.1мм хур тунадас нэмэгдүүлсэн байна.<br>Одоогоор ЦУОШГ-аас шинжилгээний дүн ирээгүй. | |
| 33 | 3.3.3 | Экспедицийн пуужин хадгалах түр агуулахад засвар үйлчилгээ хийх | Улсын төсөв | Тоо, хувь | Засвар хийгдээгүй | Төсвийн зардлаар засвар хийх | Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн аюулгүй хадгалалтын орчныг сайжруулах зорилгоор экспедицийн 15 орчим м2 талбай бүхий өрөөнд урсгал засвар ажил хийж өнгө үзэмжийг сайжруулсан. Засвар хийж зорилтот түвшинд хүрсэн | 100% |
| | | **3.4. ХАА-н цаг уурын шинжилгээний ажлын нэгдсэн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах** | | | | | | |
| 34 | 3.4.1 | Хөрсний гүний чийгийг таримал ургамлын 6 талбайд 90 удаа, ЕМ-50 хөрсний чийгийг бэлчээрийн ургамлын 1 талбайд 27 удаа тодорхойлох | Улсын төсөв | Тоо, хувь | 117 ажиглалт хийгдэж шүүмж шалгалтын дүн 99.98% | 117 ажиглалт хийх, шүүмж шалгалтын дүн 100% | 1. 3 дугаар сард бэлчээрийн ургамлын хашаалсан талбайд ЕМ-50 автомат багажийг ажиллуулж хөрсний 50 см чийгийн хэмжилтийн мэдээллийг 12 удаа хуулж боловсруулан ашигтай чийгийн нөөцийг тодорхойлсон.<br>2. Агро цаг уурын өртөө 5 дугаар сараас Хонгор сумын судалгааны улаанбуудай тариалсан 3, уриншласан 2, төмс тариалсан 1 талбайгаас нийт 36 удаа хөрсний 100см хүртэл гүний чийгийг тодорхойлж ХД-5 дэвтэр, ХХ-6 хүснэгт боловсруулж ашигтай чийгийн нөөцийг тодорхойлсон.<br>3. Нийт 48 удаагийн хөрсний ашигтай чийгийн нөөцийг арго мэдээгээр дамжуулсан.<br>Хөрсний чийгийн хөтөлбөрийн биелэлт 100%, ажиглалтын чанар 100%, мэдээ дамжуулалт 100%, шүүмж шалгалтын чанар 100%-иар дүгнэгдэж зорилтот түвшинд хүрсэн. | 100% |
| 35 | 3.4.2 | Бэлчээрийн ургамлын үзэгдэл зүйн ажиглалтыг хашаалаагүй 4 талбайд 11 ургамал дээр 880 удаа, хашаалсан 2 талбайд 5 ургамал дээр 980 удаа тодорхойлох | Улсын төсөв | Тоо, хувь | 1860 ажиглалт хийгдэж шүүмж шалгалтын дүн 99.98% | 1860 ажиглалт хийх, шүүмж шалгалтын дүн 100% | 1. Цаг уурын 2 өртөө, ХАА-н цаг уурын 2 харуул батлагдсан хөтөлбөрийн дагуу хашаалсан, хашаалаагүй талбайд бэлчээрийн ургамлын үзэгдэл зүйн ажиглалтыг ургамал цухуйсан 04 дүгээр сарын 02-оос эхлэж хийсэн. Өртөө, харуулууд хашаалсан талбайд 5 төрлийн ургамал дээр 240 удаа, хашаалаагүй талбайд 11 төрлийн ургамал дээр 110 удаа үзэгдэл зүйн ажиглалтыг хийж ХД-1, ХД-1а дэвтрүүдийг хөтөлж боловсруулсан.<br>2. Нийт 350 удаагийн ажиглалтын мэдээллийг шалгаж арго дундаж зохиож дамжуулсан.<br>Бэлчээрийн ургамлын ажиглалтын хөтөлбөрийн биелэлт 100%, ажиглалтын чанар 100%, мэдээ дамжуулалт 100%, шүүмж шалгалтын чанар 100%-иар дүгнэгдэж зорилтот түвшинд хүрсэн. | 100% |
| 36 | 3.4.3 | Төмс, улаанбуудайн үзэгдэл зүйн ажиглалтыг 4 талбайд 144 удаа тодорхойлох | Улсын төсөв | Тоо, хувь | 144 ажиглалт хийгдэж | 144 ажиглалт хийх, шүүмж | Агро цаг уурын өртөө таримал ургамал тариалсан 5 дугаар сараас улаанбуудайн 3, төмсний 1 талбайд үзэгдэл зүйн ажиглалтыг 60 удаа хийж ХД-2 дэвтрүүдийг | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шүүмж шалгалтын дүн 99.98% | шалгалтын дүн 100% | хөтөлж боловсруулсан. Нийт 60 ажиглалтын мэдээллийг шалгаж арго дундаж зохиож дамжуулсан.<br>Хөтөлбөрийн биелэлт 100%, ажиглалтын чанар 100%, мэдээ дамжуулалт 100%, шүүмж шалгалтын чанар 100%-иар дүгнэгдэж зорилтот түвшинд хүрсэн. | |
| 37 | 3.4.4 | Бэлчээрийн хортон шавж 4 талбайд 80 удаа, мэрэгчдийн тархалтыг 4 талбайд 16 удаа тодорхойлох | Улсын төсөв | Тоо, хувь | 96 ажиглалт хийгдэж шүүмж шалгалтын дүн 99.98% | 96 ажиглалт хийх, шүүмж шалгалтын дүн 100% | Цаг уурын 2 өртөө, ХАА-н цаг уурын 2 харуул батлагдсан хөтөлбөрийн дагуу 4 дүгээр сараас бэлчээрийн хортон шавжийн 40, мэрэгчдийн 8 нийт 48 удаагийн ажиглалт хийж ХД-7б дэвтэр боловсруулсан мэдээллийг шалгаж арго дундаж зохиож дамжуулсан.<br>Хөтөлбөрийн биелэлт 100%, ажиглалтын чанар 100%, мэдээ дамжуулалт 100%, шүүмж шалгалтын чанар 100%-иар дүгнэгдэж зорилтот түвшинд хүрсэн. | 100% |
| 38 | 3.4.5 | Хавар, намрын хөрсний чийг, өвлийн цасны, таримал ургамлын судалгаа 9 талбайд 4 удаа тодорхойлох | Улсын төсөв | Тоо, хувь | 4 төрлийн хэмжилт хийгдэж шалгалтын дүн 99.98% | 4 төрлийн хэмжилт хийх, шүүмж шалгалтын дүн 100% | 1. Өвлийн бэлчээрийн явуул судалгаа 1 дүгээр сард хийж ХХ-26 хүснэгт боловсруулж цасан бүрхүүлийн байдал, зудын эрсдлийг тодорхойлж дүгнэсэн.<br>2. Хаврын хөрсний чийгийн явуул судалгаа 4 дүгээр сард хийж ХД-5 дэвтэр, ХХ-6 хүснэгт боловсруулж хаврын тариалалтын өмнөх үеийн хөрсний ашигтай чийгийн нөөцийг тодорхойлж арго дундаж зохиож дамжуулсан.<br>Хөтөлбөрийн биелэлт 100%, ажиглалтын чанар 100%, мэдээ дамжуулалт 100%, шүүмж шалгалтын чанар 100%-иар дүгнэгдэж зорилтот түвшинд хүрсэн. | 100% |
| 39 | 3.4.6 | Бэлчээрийн төлөв байдлын судалгаа 9 талбайд 1 удаа хийж бэлчээрийн даац тодорхойлох | Улсын төсөв | Тоо, хувь | 9 цэгт хэмжилт хийгдэж шүүмжийн дүн 99.98% | 9 цэгт хэмжилт хийх, дүн 100% | Бэлчээрийн төлөв байдлын судалгаа жил бүрийн 8 дугаар сарын дунд 10 хоногт хийх тул хугацаа болоогүй. | - |
| 40 | 3.4.7 | 10 хоногийн агро дундаж мэдээг сард 3 удаа 36 удаа зохиож, шалгаж, дамжуулах | Улсын төсөв | Тоо, хувь | 36 мэдээ дамжуулсан дүн 99.98% | 36 мэдээ дамжуулах, дүн 100% | Өртөө, харуулуудаас зохиож ирүүлсэн 10 хоногийн агро дундаж мэдээ нийт 18 удаа шалгасан.<br>Агро дундаж мэдээ дамжуулалт 100%-иар дүгнэгдэж зорилтот түвшинд хүрсэн.100% | 100% |
| | | **Зорилт 3.5. Холбоо сүлжээ, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах** | | | | | | |
| 41 | 3.5.1 | Интернэтийн сүлжээ ашиглалт, тоног төхөөрөмжийн хэвийн аюулгүй байдлыг хангах, мэдээ солилцоо, дамжуулалтыг өдөр бүр хянах | Улсын төсөв | Тоо, хувь | 7850 мэдээний дамжуулалт 99,99 % | 7850 мэдээний дамжуулалт 99,99 % | 2025 оны 12 сард univision-ний шилэн кабель тавигдаж интернэтийн хурдыг 16Mbps болсноос хойш интернэтийн тоног төхөөрөмж хэвийн ажиллаж байна.<br>Салбаруудын бүх мэдээ, мэдээлэл 100% дамжигдаж зорилтот түвшинд хүрч ажилласан. | 100% |
| 42 | 3.5.2 | darkhan-uul.weather.gov.mn сайтын 1680 мэдээлэлд | Улсын төсөв | Хэвийн ажиллагааг хангах | Сайтад мэдээлэл | Сайтуудыг хэвийн ажиллуулж | 1. Төвийн даргын 2026 оны А/07 дугаар тушаалын хавсралтаар www.darkhan-uul.weather.gov.mn цахим хуудсанд тавигдах мэдээний жагсаалт батлагдсан. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | darkhan-uul.namem.gov.mn цахим хуудасны хэвийн ажиллагааг хангах, хяналт тавих | | | бүрэн тавигдсан | мэдээллийг 10% тавих | Эхний хагас жилийн байдлаар ус судлал, хөдөө аж ахуй, орчны шинжилгээ, цаг уурын нийт 475 мэдээ мэдээлэл нийтэлсэн. Дээрх мэдээллүүдийн хүчинтэй хугацаа буруу сонгогдсоноос хэрэглэгчдэд харагдахгүй байсан асуудлыг цаг тухайд нь илрүүлж, холбогдох албан хаагчдад мэдэгдэн засварлуулж иргэдийг зөв мэдээллээр хангаж ажиллаж байна.<br>2. Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангаж darkhan-uul.namem.gov.mn цахим хуудас тасралтгүй хэвийн ажиллаж, мэдээ мэдээллийг нийтлэн хэрэглэгчдэд хүргэж байна. | |
| 43 | 3.5.3 | Цаг уурын AWS 310 автомат станц, нарын 310R автомат станц, HUAYUN чийг, температур хэмжигч төхөөрөмжүүдийн хэвийн, тасралтгүй ажиллагааг хангах, техник тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих | Улсын төсөв | Хэвийн ажиллагааг хангах | 3 автомат станц болон 2 төхөөрөмж-ийн хэвийн ажиллагааг хангах | 3 автомат станц болон 2 төхөөрөмж-ийн хэвийн ажиллагааг хангах | 1. Дархан, Шаазгайт өртөөдийн цаг уурын AWS-310 автомат станцын 1 минут тутамд илгээх **Weather Platform** систем http://119.40.97.105:8080/ хэвийн ажиллаж байна.<br>2. Нарын цацраг судлалын 310R автомат станц хэвийн ажиллаж байгаа.<br>3. Багаж хэмжилзүйн нженертэй хамтран 5 дугаар сард Дархан өртөөний AWS 310 автомат станцын салхины мэдрүүрийг буулгаж гол төмрийн 2 шаарикийг сольж, тоос, шороог цэвэрлэх ажлыг хийсэн. ХАА-н цаг уурын Хонгор, Шарын гол харуулын HUAYUN төхөөрөмжийн чийгийн мэдрүүрийн ажиллагаа доголдсонг илрүүлсэн. | 100% |
| 44 | 3.5.4 | Төвийн компьютер, принтер, киоск, ухаалаг дэлгэц, камер, бусад тоног төхөөрөмжид тохируулга үзлэг үйлчилгээ хийх | Улсын төсөв | Үйлчилгээ-ний тоо | Компьютер , принтер, 3 төхөөрөм-жид үзлэг, үйлчилгээ 100% хийсэн | Компьютер, принтер, төхөөрөмж-үүдэд үзлэг, үйлчилгээг 100% хийх | Компьютер, хэвлэгч болон бусад техник хэрэгслийн үзлэг, үйлчилгээ хийх төлөвлөлтийг 2026 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр төвийн даргаар батлуулж, хуваарийн дагуу дараах ажлууд хийгдсэн. Үүнд:<br>1. Байгууллагын хэмжээнд ашиглагдаж байгаа 39 компьютероос эхний хагас жилээр 17 компьютерт үзлэг, техникийн засвар үйлчилгээ, цэвэрлэгээ, программ хангамжийн шинэчлэл, вирусийн шалгалт гэх мэт ажлууд хийгдэж эд хариуцагчид танилцуулж техник ашиглалтын паспорт хөтлөж хүлээлгэн өгсөн. 12 компьютерийн процессорын дулаан дамжуулах тосыг сольж шинэчилсэн. Мөн ЦУОШГ-аас шагналд ирсэн шинэ суурин компьютерыг хүлээн авч №07 техник ашиглалтын паспорт нээж бүртгэлжүүлэн, шаардлагатай тохиргоог хийж ажилд оруулав. УЦУОШТөвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 39 компьютер ашиглаж байгаагаас 2021-2025 онд ашиглалтад орсон 24 компьютер байгаа нь нийт компьютерийн 58%-ийг эзэлж байна. 2016-2020 онд ашиглалтад орсон 5-10 жилийн насжилттай 11 компьютер байгаа нь нийт компьютерийн 26%-ийг эзэлж байна, үлдсэн 16% буюу 6 компьютер нь 2011- | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2015 оны 10 ба түүнээс дээш жилийн насжилттай, элэгдлийн хугацаа дууссан, техникийн шаардлага хангахгүй болсон.<br>2. Төвийн хэмжээнд ашиглагдаж буй 17 принтерийн хэвийн ажиллагааг хангаж, хор цэнэглэлтийн бүртгэл хөтөлж байна. Эхний хагас жилийн байдлаар 10 принтерт хор цэнэглэж, 4 принтерт шинэ савтай хор суурилуулан, цэвэрлэгээ тухай бүр хийж ажиллаж байна. Хор цэнэглэлтийн бүртгэл хөтөлсөнөөр байгууллагын хэмжээнд жилд хэрэглэх хорны судалгааг гаргаж 2027 оны төсвийн төсөл, төсөөлөлд бодитой тооцоог санхүүд гаргаж өгсөн.<br>3. Угтах үйлчилгээний хэсгийн ухаалаг мэдээллийн самбар /киоск/-т техник ашиглалтын дэвтэр нээж, 2025 онд дэлгэц дээр гарсан гэмтэл /4см орчим хар зураас үүссэн/ ашиглалт болон хамгаалалтын талаарх мэдээллийг бичиж бүртгэл хөтөлж байна. Дэлгэцийн гэмтэл киоскийн үйл ажиллагаанд нөлөөлөөгүй. Эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалж бүх тоног төхөөрөмжүүдийг гэмтлээс урьдчилан сэргийлж өдөр тутам шалгалтын хуудсаар ажиллагааг хянаж байна.<br>4. Хурлын зааланд байрлах 86 инчийн ухаалаг самбарын дэлгэц, процессор хэвийн ажиллагаатай байгаа бөгөөд ухаалаг самбарын хуучин гар гацалттай байсныг Logitech MK270R загварын утасгүй гар, keyboard шинээр худалдан авч сайжруулалт хийсэн.<br>5. Тасралтгүй ажиллагаатай Дархан өртөөний албан хаагчдад сүлжээний тоног төхөөрөмж, төвийн хяналтын камерын систем, AWS310 автомат станц болон галын аюулын дохиолол, төхөөрөмжүүдийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч танилцуулга хийсэн. | |
| | | **Зорилт 3.6. Архив, мэдээллийн дэд сангийн үйл ажиллагааг хангах** | | | | | | |
| 45 | 3.6.1 | Шинжилгээний архивын бүрдүүлэлт:<br>1. 2026 оны нөхөн бүрдүүлэлтийн төлөвлөгөө<br>2. Баримтын тоо хэмжээ/ADRSS/<br>3. БНШК-ын хурлын тэмдэглэл<br>4. Маягт-1,2 хүснэгт<br>5. 1991-1993 оны ЦД-1дэвтрийн бүрдүүлэлт | Улсын төсөв | Хугацаа, чанар | 5 төрлийн бүрдүүлэлт-ийн ирц 100%, чанар 99.92% | 5 төрлийн бүрдүүлэлт-ийн ирц 100%, чанар 99.93% | 1. Тус төвийн шинжилгээ, мэдээлэл, үйлчилгээний 2025 оны цаасан болон цахим баримт нөхөн бүрдүүлэх төлөвлөгөөг 2026 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр төвийн даргаар баталгаажуулж АМСХ-т ftp сүлжээнд байршуулсан.<br>2. Архивын баримтын бүртгэл, эрэлт хайлтын систем (ADRSS)-ийн программд ус, цаг агаарын зураг мэдээ, уур амьсгал, ХАА-н цаг уур, БОШЛаборатори зэрэг 5 салбарын 2025 оны 7332 хуудас бүхий 64 х.н-ээр нэмэгдэж нийт 258384 хуудас бүхий 1983 х.н-ийн бүртгэгдэж АМСХ-т хугацаанд нь хүргүүлсэн.<br>3. БНШК-ын эхний хагас жилд 2 удаа хуралдаж 5 асуудлыг шийдвэрлэсэн. Үүнд: | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ✓ Цаг уур-уур амьсгалын баримтын хөмрөгт байгаа Дархан өртөөний 36 ширхэг дэвтрийг бүрэн бүрдэлтэй болгож ЦУОШГ-ын Ахлах архивч, зааварлагч, арга зүйч Х.Туулцэцэгт хүлээлгэн өгч "Баримт шилжүүлсэн акт' үйлдсэн.<br>✓ Байгууллагын архивын үйл ажиллагаанд үүссэн 2025 оны данс бүртгэлийн хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг хэлэлцэж батлуулсан.<br>✓ Байгууллагын архивын устгах хэргийн баримтын жагсаалтыг хэлэлцэж аймгийн БНШАЗК-оор батлуулах хүсэлтээ албан бичгээр хандсан.<br>✓ Тус төвийн байгууллагын архив, шинжилгээний архив 2 нэг өрөөнд байсан тул ХЗДХСайдын 2025 оны А/100 дугаар тушаалаар батлагдсан "Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам"-ын 6.4-т "Архив нь зориулалтын өрөө тасалгаатай байна" гэж заасны дагуу урьдчилан мэдээлэх салбарын 35 м2 талбайтай том өрөөг 11.18 м2 хэмжээтэй вакум хаалтаар тусгаарлаж шинжилгээний архивын өрөө үүсгэж стандартад нийцүүлэх ажил хийгдэж төсвөөс 2,054,000 төгрөгний зардал гарсан.<br>✓ Комиссын гишүүдэд ЦУОШГ-ын даргын 2025 оны А/278 тушаалаар батлагдсан "Байгууллагын дэргэдэх БНШК-ын дүрэм", Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам"-ыг судлах үүрэг өгсөн.<br>4. Маягт-1, Маягт-2-ын тайлан 11 дүгээр сарын 20-нд тул хугацаа болоогүй.<br>5. Дархан өртөөний 1991-1993 оны 36 ширхэг ЦД-1 дэвтрийн бүрдүүлэлтийг хийж 2081 kb хэмжээтэй 1275 файлыг 05 дугаар 07-ны өдөр АМСХэлтэст хүргүүлсэн. 1.98 gb хэмжээтэй файлыг цахимжуулан 05 дугаар сарын 01-ний дотор WAMS-н санд байршуулсан. **АМСХэлтсээс ирсэн шинжилгээний архивын эхний хагас жилийн дүн 100%** | |
| 46 | 3.6.2 | Мэдээллийн дэд сан:<br>1. Уур амьсгалын горимын мэдээллийн сан бүрдүүлэх /isx.mab/<br>2. Төрөлжсөн мэдээллийн сан бүрдүүлэх /aws/ | Улсын төсөв | Тоо, хувь | Горимын 12, төрөлжсөн 12 нийт 24 мэдээллийн актын дүн 99.89% | Горимын 12, төрөлжсөн 12 нийт 24 мэдээллийн актын дүн 99.90% | Мэдээллийн дэд санд дараах мэдээллийг хүргүүлсэн. Үүнд:<br>1. Уур амьсгалын горимын мэдээллийн санд цаг уурын 2 өртөө, ХААЦУ-ын 2 харуулын өртөөний 2025 оны 12 дугаар сар, оны эхний 5 сарын цаг уурын ажиглалтын isx, tab, res, шүүмжийн түүвэр 223 kb хэмжээтэй 4 файл, нийт 2478 kb хэмжээтэй цахим мэдээ хүлээн авсан 6 актыг үйлдэн ftp сүлжээгээр сар бүрийн 05-ны дотор АМСХэлтэст 100% хүргүүлсэн. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2. Төрөлжсөн мэдээллийн санд Дархан өртөөний 2025 оны 12 дугаар сар, оны эхний 5 сарын автомат станцын 34.66 mb хэмжээтэй 360 файл, нарны автомат станцын 8.14 mb хэмжээтэй 180 файл, Шаазгайт өртөөний автомат станцын 31.67 mb хэмжээтэй 300 файл нийт 74.47 mb хэмжээтэй 840 файлыг 6 удаагийн акт үйлдэж ftp сүлжээгээр АМСХ-т хугацаанд нь 100% хүргүүлсэн. **АМСХэлтсээс ирсэн мэдээллийн дэд сангийн эхний хагас жилийн дүн 100%** | |
| | | **Зорилт 3.7. Байгаль орчны шинжилгээний ажлын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах** | | | | | | |
| 47 | 3.7.1 | Агаарын чанарын хяналтын автомат станцын хэвийн ажиллагааг хангах, бохирдуулагч 6 үзүүлэлтийн үр дүнг гаргах | Улсын төсөв | Тоо, хувь | 6 сар туршилтын хэмжилт хийгдсэн. | 6 төрлийн үзүүлэлтийн 2190 хэмжилт тасралтгүй хийх, дүн 100% | 1. АЧХ-ын автомат станцын хэмжилтийн болон туслах тоног төхөөрөмжийг өдөр бүр, 7 хоног, сар бүрийн хяналтыг хуваарийн дагуу нийт 211 удаа хяналт хийж тохиргоо, үйлчилгээг хийгдэж 6 үзүүлэлтийн 1086 хэмжилтээс 1074 удаа хэмжилт хийгдсэн. Зөвхөн озоны ламп доголдож 12 өдрийн хэмжилт хийгдээгүй.<br>2. Эхний 5 сарын байдлаар MNS4585:2025 стандартын хүлцэх агууламжаас хүхэрлэг хий 9.3%, азотын давхар исэл 18%, PM10 тоосонцор 26%, PM2.5 тоосонцор 37%-д давсан бохирдолтой байна. АЧ-ын индексийн үнэлгээгээр /PM10 тоосонцор/ бохирдолтой ангилалд байна.<br>Шинжилгээний ажлын хөтөлбөрийн биелэлт 100%, мэдээ дамжуулалт 100% | 100% |
| 48 | 3.7.2 | Гадаргын усны 47 дээж хаягдал усны 48 дээжид хяналт шинжилгээ хийж усны чанарын тодорхойлох | Улсын төсөв | Тоо, хувь | Шинжилгээ хийгдсэн дүн 99.78% | Шинжилгээ-ний дүн 99.9% | 1. Шинжилгээний ажлын хөтөлбөрийн дагуу гадаргын усны чанарын 3 голын 5 цэгээс 21 дээж авч MNS, ISO стандартын дагуу 24 үзүүлэлтээр шинжилгээ хийсэн. Шинжилгээний дүнг гадаргын усны чанарын MNS4586:2024 стандарттай харьцуулахад 04 дүгээр сард Шарын гол-Автозамын гүүр, Шарын гол-Усны харуулын цэгт перманганатын исэлдэх чанар 2.4-4.6 дахин давж бохирдсон. Бусад цэгт стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан бохирдол илрээгүй.<br>2. Хаягдал усны чанарыг 5 цэгээс 28 дээж авч химийн 12 үзүүлэлтээр шинжилгээ хийгдсэн. Шинжилгээний дүнг MNS4943:2015 стандарттай харьцуулахад Төв цэвэрлэх байгууламж дээр 1 дүгээр сард перманганатын исэлдэх чанар зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 1.1 дахин, Хонгор сумын цэвэрлэх байгууламж дээр 3 дугаар сард 1.4 дахин давсан. Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч 2-4 дүгээр сард бүх цэгүүдэд 1.2-2 дахин, нийт азот (аммонийн азот, нитрат, нитрит) 3 дугаар сард Салхит өртөөний цэвэрлэх байгууламж дээр 1.1 дахин давсан бохирдолтой байлаа. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 3. Төв цэвэрлэх байгууламжийн цэвэрлэгээний чанар 92.4-93.1%, Шарын гол, Салхит өртөө, Орхон сумын цэвэрлэх байгууламжуудийн чанар 72.1-75.0%, Хонгор сумын цэвэрлэх байгууламжийн чанар 50%-тай цэвэрлэгдсэн байна.<br>Шинжилгээний ажлын хөтөлбөрийн биелэлт 100%, мэдээ дамжуулалт 100% | |
| 49 | 3.7.3 | Хөрсний чанарын 11 дээжид 77 үзүүлэлтээр шинжилгээ хийж дүнг тайлагнах | Улсын төсөв | Тоо, хувь | Шинжилгээ-ний дүн 99.47% | Шинжилгээ-ний дүн 99.85% | 2026 оны 05 дугаар сарын 08-нд Дархан сумын суурьшлын бүсэд 11 цэгт хөрсний агрохимийн шинжилгээг 7 үзүүлэлтээр MNS3310:1991 стандартын дагуу тодорхойлсон. Шинжилгээний дүнгээр<br>✓ сульфатын /SO4/ агууламж 20.1-52.9мг/кг, ДЦС-ын орчинд хамгийн их агууламж илэрсэн ч зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан бохирдолгүй<br>✓ нитратын /$NO_3$/ агууламж 4.5-16.9 мг/кг, хамгийн их агууламж “Дашваанжил" ахуйн хэрэглээний ЦС-ийн орчинд илэрсэн ч MNS3297:2019 стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан бохирдолгүй байна.<br>Шинжилгээний ажлын хөтөлбөрийн биелэлт 100%, мэдээ дамжуулалт 100% | 100% |
| 50 | 3.7.4 | БОШЛ-ийн итгэмжлэлийн MNS ISO/IEC17025:2018 стандартын шаардлага хангаж ажиллах | Улсын төсөв | MNS ISO/IEC 17025:2018 стандарт | 2024 онд ҮИТ-өөс хийгдсэн үнэлгээнд хамрагдсан | Стандартын шаардлагын хэрэгжилт-ийг хангах | 1. 03 дугаар сард БОУАӨЯ-наас Дархан-Уул аймгийн УЦУОШТ-ийн БОШЛ-ийн химийн бодисын ашиглах 2026-2030 он хүртэл хүчинтэй тусгай зөвшөөрөл авсан.<br>2. 3-5 дугаар сард БОШЛ-ийн итгэмжлэлийн MNS ISO/IEC 17025:2018 стандартын нөөцөд тавих 6.2-6.4 шаардлага, үйл явцын 7.1-7.10 шаардлагын нийцтэй байдлыг хянаж 4 сайжруулах арга хэмжээний хэрэгжилтийг хангасан.<br>3. 5 дугаар сард MNS ISO/IEC 17025:2018 стандартын 8.8 шаардлагын дагуу БОШЛ-т дотоод аудит хийгдэж БОШЛ-ийн үйл ажиллагаанд илэрсэн 3 үл тохирлыг залруулж 2026 оны 06 дугаар сарын 10-ны дотор нийцлийг хангаж тайлагнах, цаашид лабораторийн MNS ISO/IEC17025:2018 стандартын нөөцөд тавих шаардлага 6.2-6.6 болон үйл явцын шаардлагын 7.1-7.11 шаардлагын нийцтэй байдлыг бүрэн хангаж ажиллах чиглэлээр өгсөн 9 зөвлөмжийн хэрэгжилтийг 7 дугаар сарын 25-ны дотор хэрэгжилтийг тайлагнахыг инженерүүдэд үүрэг болгосон. Цаашид инженерүүд чиг үүргийн дагуу ажил гүйцэтгэх, мэргэжил ур чадвар, ажил гүйцэтгэх хурд, баримт бичгийн эмх цэгцээ сайжруулж ажиилахыг зөвлөв. | 100% |
| | | **Зорилт 3.8. Багаж, хэмжлийн нэгдмэл байдлыг хангах** | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 51 | 3.8.1 | Цаг уурын 3 автомат станц, 1 цахилгаан барометрийг БОХЗТЛ-т, цацрагийн түвшин хэмжигч 2 багажийг Цөмийн энергийн төвд, 2 цахилгаан жинг аймгийн Стандарчилал хэмжилзүйн хэлтэст шалгуулж баталгаажуулалтанд хамруулах | Улсын төсөв | Тоо, хувь | Нийт 6 багаж баталгаажсан. | 8 багажийн ажиллагааг шалгуулж баталгаажуулах | Төвийн 2026 оны багаж, хэмжих хэрэгсэлийг баталгаажуулах төлөвлөгөө 1 дүгээр сард батлагдаж хуваарийн дагуу доорх багажуудыг шалгуулсан.<br>1. Төлөвлөлтийн дагуу 04 дүгээр сард БОХЗТЛ-д цахилгаан барометр шалгагдаж тэнцсэн тул улсын шалгагчийн Г-2026/10 дугаартай гэрчилгээ олгогдсон. Цөмийн энергийн төвд цацрагийн түвшин хэмжигч 2 багаж шалгагдаж ажиллагаа нь тэнцсэн тул №26/115, №26/116 дугаартай гэрчилгээ тус тус олгогдсон.<br>2. 05 дугаар сард аймгийн Стандарчилал хэмжилзүйн хэлтэст БОШЛ-ийн электрон жингийн ажиллагаа шалгалтанд тэнцэж №ДаМЦЛ-2026-026, №ДаМЦЛ-2026-027 дугаартай гэрчилгээ олгогдсон. | 100% |
| 52 | 3.8.2 | Төвийн багажийн инженер цаг уурын хэмжих хэрэгслийн ажиллагааг шалгах, тохируулга хийж хэмжилзүйн нэгдмэл байдлыг хангах | Улсын төсөв | Үйлчилгээ хийсэн тоо, хувь | 7 төрлийн хэмжих хэрэгслийг шалгаж, тохируулга, үйлчилгээ 100% хийгдсэн. | 7 төрлийн хэмжих хэрэгслийг шалгаж, тохируулга, үйлчилгээ 100% хийх | 1. 2026 оны 01 дүгээр сард батлагдсан төлөвлөгөөний дагуу эхний хагас жилд доорх ажлууд хийгдсэн.<br>2. Цаг уурын өртөө, харуулын анериод барометр 4, гигрометр 3, флюгер 2, цасны жин 4, цахилгаан жин 4, хурын хувин 4, хэмжих аяга 4 нийт 25 багажинд шалгалт тохируулга, үйлчилгээ хийгдсэн Үзлэгийн явцад хурын хувингийн цоргоны таглаа байхгүй, тунадас хэмжигчийн ялтасны холбоосыг тэгшлэх, тулга нь сууринаасаа салсан зэрэг үл тохирлыг тухай бүр арилгаж ажиллахыг үүрэг болгов. Цаашид механик багажийн арчилгаа, үйлчилгээг тогтмол хийх, шалгалт тохируулгын хугацааг мөрдөх, хэмжих хэрэгслийн хадгалалт, хамгаалалтанд анхаарах, техникийн паспортын хөтлөлтийг сайжруулах талаар мэргэжил, арга зүйн зөвлөмж өгч ажиллав.<br>3. Ус судлалын 3 харуулд ашиглагдаж байгаа усны температур хэмжигч PH болон термометрүүдийн ажиллагааг шалгалтын эталон багажтай харьцуулахад 0.1-0.7 градусын зөрөөтэй зөвшөөрөгдөх хэмжээнд байлаа.<br>4. Дархан-Бороо экспедицийн агаарын температур, чийг хэмжигч HUAYAN төхөөрөмж, агаарын даралт хэмжигч анероид барометрийн ажиллагааг харьцуулсан тоололт хийж ажилд тэнцсэн тухай хэмжих хэрэгслийн шалгалт тохируулгын хуудас олгосон.<br>5. Дархан өртөөний нарны 310R хэвийн ажиллаж байна.<br>6. Тус төвийн шалгалтын эталон багажийн температурын мэдрүүрийн ажиллагаа хэвийн, чийгийн мэдрүүр нь гэмтэлтэй, засварлах боломжгүй гэсэн дүгнэлт гарсан. Цаг харуулын Хонгор, Шарын гол харуулын HUAYUN чийг, температур хэмжигч төхөөрөмжийн чийгийн мэдрүүр мемори солих үед гацах, тоололт орж ирэхгүй байх доголдол үүсээд байгаа тул сэлбэг хэрэгсэл | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | нийлүүлэгдэх хүртэл гигрометрээр хэмжилт хийгдэж байна. Цаашид VAISALA, HUAYUN HMP110 мэдрүүрээр хангах шаардлагатай байна.<br>7. 05 дугаар сард Дархан өртөөний цаг уурын автомат станцын салхины мэдрүүрийг буулгаж, гол төмрийн 2 шаарикийг сольж, тоос, шороог цэвэрлэж тавьсан.<br>8. Дархан өртөөний ажиглалтын талбайн хашааны ашиглалтын хугацаа дуусч актласан тул цаг уурын ажиглалт, хэмжлийн технологийн заавар (ШЗ.II.01.03.2014) -ын 2.1.4 дэх хэсгийн 19-д заасны дагуу стандарт шаардлагад нийцүүлэн шинээр хашаа барьж ашиглалтад оруулла. 2024 онд ЦУОШГ-аас нийлүүлэгдсэн хашааны зориулалтын тор, шон болон төсвийн урсгал зардлаар хийгдсэн.<br>9. Дархан өртөөний AWS-310 автомат станцын хурын хувинг заавры дагуу 1.5 м-ийн өндөрт байрлуулсан. | |
| 53 | 3.8.3 | Цаг уурын Шаазгайт өртөөний газардуулгын эсэргүүцлийн хэвийн ажиллагааг хангах | Улсын төсөв | Хэрэгжилт хувиар | Стандартад /8-10 Ω/ заасан хэвийн хэмжээнээс 5 дахин давсан | Эсэргүүцлийг стандартад заасан хэмжээнд хүргэх | 2025 онд Шаазгайт өртөөний цаг уурын AWS310 автомат станцын ерөнхий газардуулгын эсэргүүцлийг HABOTEST HT2302 Earth Resistance Tester багажаар хэмжихэд стандартын зөвшөөрөгдөх хэмжээнээс 4.9 дахин давж 48.7 Ом(Ω) гарч байсан. Төлөвлөлтийн дагуу 5 дугаар сард аянга зайлуулагч газардуулгыг заавры дагуу шинээр хийж эсэргүүцлийг хэмжихэд 10 Ом(Ω) болж стандартын зөвшөөрөгдөх хэмжээнд хүрч автомат станцын аюулгүй байдал хангагдлаа. 6 дугаар сард эсэргүүцлийг дахин хэмжихээр төлөвлөж байна. Газардуулгын ажлын зардалд төсвөөс 1.4 сая төгрөгийг зарцуулсан. | 100% |
| 54 | 3.8.4 | Батлагдсан хуваарийн дагуу салбаруудын шинжилгээний ажлын хөтөлбөрийн хэрэгжилт, ажиглалтын технологийн мөрдөлтөд шалган зөвлөх ажил хийж тайлагнах | Улсын төсөв | Тоо, үнэлгээ | Дотоод хяналт хийгдэж хангалттай үнэлэгдсэн. | 10 салбар шалгаж үнэлгээ дүгнэлт зөвлөмж өгч тайлагнах | 2026 оны шинжилгээний ажлын технологийн дотоод хяналт, шалган зөвлөх ажлын хуваарь 1 дүгээр сард батлагдсан. Эхний хагас жилийн байдлаар 10 салбар нэгжид дотоод хяналт, шалган зөвлөх ажил хийж дүгнэж, зөвлөмж өгч ажилласан.<br>1. Цаг уурын чиглэлийн 7 салбар ЦУОШГ-ын даргын 2016 оны А/16, 2020 оны А/75 дугаар тушаалын хөтөлбөрийн дагуу ЦУОШХШ-ний ажиглалт, хэмжлийн технологийн заавар/ ШЗ.II.01.03.2014/, хөдөө аж ахуйн цаг уурын заавры /ШЗ.Х.03-05-2011/ хэрэгжилтийг шалгахад салбаруудад ашиглагдаж буй багаж, хэмжих хэрэгслийн өөрчлөлтийн талаар багаж хэмжилзүйн инженерт шуурхай мэдээлж байх, төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, үүл, үзэгдлийн ажиглалтын уялдаа холбоог сайжруулах, хугацаатай тайлан мэдээг хоцроолгүй ирүүлэх зэрэг 2-3 зөвлөмж, төрийн үйлчилгээний хүсэлтийн бүртгэл хяналтын системийг нэвтрүүлж үйлчилгээ үзүүлэх, цаг агаарын аюултай үзэгдлийн мэдээллийг | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | давхар дохионы хэлээр хүргэх ажлыг зохион байгуулах, урьдчилсан мэдээний таарцыг улсын дундаж болон зорилтот түвшинд хүргэн ахиулах, шинжилгээний ажиглалтын талбайн газрыг стандартын шаардлагад нийцүүлэн шинээр судлаж 2027 оны аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулах зэрэг 4-5 үүрэг даалгавар өгсөн. Дотоод хяналтад хамрагдсан салбарууд “Хангалттай” үнэлэгдсэн ба 3 салбар үүрэг даалгаврын хэрэгжилтийг 97.5%-тай гүйцэтгэсэн байна. Бусад салбарын үүрэг даалгаврын хэрэгжилтийн хугацаа болоогүй.<br>2. БОШЛ-т 5 дугаар сарын 04-15-нд MNS ISO/IEC 17025:2018 стандартын 8.8 шаардлагын дагуу БОШЛ-т дотоод аудит хийгдэж 3 үл тохирлыг залруулах, цаашид нийцлийг хангаж хугацаатай тайлагнах, лабораторийн MNS ISO/IEC17025:2018 стандартын нөөцөд тавих шаардлага 6.2-6.6 болон үйл явцын шаардлагын 7.1-7.11 шаардлагын нийцтэй байдлыг бүрэн хангаж ажиллах талаар 10 зөвлөмж өгч хэрэгжилтийг тайлагнах 1 сарын хугацаатай үүрэг чиглэл өгсөн. | |
| | | **Зорилт 3.9. Усны горим, нөөцийн хяналт, шинжилгээний ажлын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах** | | | | | | |
| 55 | 3.9.1 | Усны горим, нөөцийн хяналт, шинжилгээний ажил хийх | Улсын төсөв | Тоо, хувь | 3 харуул 1405 ажиглалт хийсэн нэгдсэн дүн 98,57% | 3 харуул 1651 ажиглалт хийх, нэгдэн дүн 98,70% | 1. Эхний хагас жилийн байдлаар гадаргын усны горимын ажиглалт, хэмжилтүүд хөтөлбөрийн дагуу 100% хийгдэж УД-1 дэвтэр 18, УД-2 дэвтэр 41 нийт 59 тайланд шүүмж шалгалт хийж, **Q=f(H) F=f(H), Y=f(H)** муруйн хамаарлын хувь 100% дүгнэгдсэн.<br>2. Хараа, Шарын гол харуулын усны түвшний өдөр тутмын 122 мэдээг хяналтын системээр дамжуулсан. Тасарсан, хугацаа хоцорсон мэдээ байхгүй<br>3. Эхний 5 сарын УХШ-1 мэдээг 6 удаа зохиосон, 9 төрлийн 54 мэдээ боловсруулж сар бүрийн 18-нд ГУСХэлтэст дотоодын FTP сүлжээгээр дамжуулсан.<br>4. Усны горим, нөөцийн шинжилгээний ажлын УХШ-1 мэдээний I улирлын нэгдсэн дүн 100%-иар дүгнэгдсэн. | 100% |
| 56 | 3.9.2 | 3 голын ажиглалтын мэдээ боловсруулж урсацын тайлан гаргах | Улсын төсөв | Тоо, хувь | 2024 оны урсацын дүн 97.30**%** | Урсацын дүн 97.40% | 2025 оны голуудын усны урсацын жилийн эмхэтгэлийг “РЕКИ-РЕЖИМ” программаар урсацын тооцоог боловсруулж шалган цахим тайланг 3 дугаар сарын 05-нд ГУСХэлтэст илгээсэн. Урсацын ирц 100%, урсац бодолтын чанар 97.5%-тай дүгнэгдэж зорилтод түвшингээс 0.1%-иар өссөн. | 100% |
| | | **Зорилт 3.10. Судалгааны ажил** | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 57 | 3.10.1 | Агро цаг уурын Дархан өртөөний 2025 оны шинжилгээний ажлын мэдээлэл боловсруулж тайлан гаргах | Улсын төсөв | Тайлан | 2024 оны тайланг хэлэлцүүлсэн. | 2025 оны тайланг хэлэлцүүлэх | 2025 оны Агро цаг уурын шинжилгээний ажлын тайлан нь судалгааны арга зүй, 2025 оны цаг агаарын нөхцөл, бэлчээрийн ургамал, буудай, төмсний үе шатны цаг уурын нөхцөл, ургалтын байдал, дулаан, чийгийн хангамж, бэлчээрийн төлөв байдал, явуул судалгаа, мэдээлэл үйлчилгээ гэсэн 7 бүлэг 43 хүснэгт, 51 зураг, дүгнэлт, ашигласан хэвлэлийн жагсаалтаас бүрдсэн 59 хуудас бүхий тайланг шүүмжийн шатанд УЦУСМХ-ийн ХААЦУСХэлтсийн технологич инженер Б.Ганцэцэгт цахимаар илгээсэн. | 100% |
| 58 | 3.10.2 | Дархан-Уул аймгийн уур амьсгал-ын лавлахын боловсруулалтын ажлыг эхлэх | Улсын төсөв | Хувь | 2014 онд дата түүвэр эмхэтгэсэн. | Лавлахын ажлын гүйцэтгэл 20 % | Тус төвөөс УЦУОСМХ-ийн УАӨНСХэлтэстэй хамтран “Дархан-Уул аймгийн уур амьсгал, гадаргын усны нөөцийн лавлах” боловсруулах ажлыг эхлүүлж ЭШ -ний ажилтан, Доктор (Ph.D) Д.Дуламсүрэнтэй лавлах боловсруулах арга зүйн зөвлөхөөр ажиллуулах гэрээ байгуулсан. 4 дүгээр сард лавлах боловсруулах талаар анхны сургалт зохион байгуулсан. Тайлант хугацаанд дараах үндсэн ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн.<br>1. Уур амьсгалын мэдээллийн цуваа бүрдүүлэх<br>2. Хэрэглээний уур амьсгалын үзүүлэлтүүдийг тооцоолох<br>3. Өгөгдлийн чанарын хяналт, нөхөн бүрдүүлэлт хийх<br>4. Өндөр нарийвчлалтай зураглал боловсруулах (температур, хур тунадас, уур амьсгалын бүсчлэл, тархалт гэх мэт)<br>5. Лавлахын эх бэлтгэх, бичвэр боловсруулах | 100% |
| 59 | 3.10.3 | Шарын гол сумын уур амьсгал, орчны төлөв байдлын судалгаа хийж тайлагнах | Улсын төсөв | Тайлан хувь | Иж бүрэн судалгаа хийгдэж байгаагүй | Судалгааны үр дүнг тайлагнах | Дархан-Уул аймгийн Шарын гол сумын уур амьсгал, орчны төлөв байдлын судалгааны ажлын эхний хэсэг 2025 оны VI улиралд, 2 дахь хэсэг 2026 оны I улиралд хийгдсэн. Шарын гол сумын физик газар зүйн нөхцөл, орчны чанарын суурь судалгаа, цаг агаар, уур амьсгалын өөрчлөлт, агаар, ус, хөрсний чанар, сумын бэлчээрийн төлөв байдлын цогц судалгаа хийгдэж 5 бүлэг, 26 зураг, 18 хүснэгт, дүгнэлт, зөвлөмж, 21 хуудас хавсралт боловсруулсан 55 хуудастай тайлан гаргасан. Судалгааны үр дүнд Шарын гол сумын өнөөгийн уур амьсгал, орчны төлөв байдалд тулгуурлаж сум орон нутгаа хөгжүүлэх бодлого боловсруулах, орчны чанарыг сайжруулах, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, эрсдэлийн менежментийн төлөвлөлт хийх, цаашид анхаарах асуудлыг дэвшүүлсэн анхдагч суурь судалгаа болсон. 5 дугаар сард сумын Засаг дарга М.Мөнхбаяр, Засаг даргын орлогч дарга Э.Дамдиндорж нарт танилцуулан хүлээлгэж өгч цаашид орон нутагтаа хамтын ажиллагааг өргөжүүлэх бодит ажил боллоо. | 100% |

**ДӨРӨВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ**

| Д/д | Арга хэмжээ | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 4.** Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн үйл ажиллагааг ард иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад сурталчилах, мэдээллээр үйлчлэх **Зорилтын уялдаа, холбоо:** Ус цаг уур орчны шижилгээний салбарын стратеги төлөвлөгөөний Зорилт-5-ын 1, 2, 5, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль, 2016 оны А02, Цаг уур орчны шинжилгээний газрын даргын 2016 оны А02 тушаал “Хөтөлбөр батлах тухай”, Засгийн газрын 2015 оны 286 дугаар тогтоолын хүрээнд | | | | | | | |
| 60 | Цаг агаарын урьдчилсан мэдээллээр үйлчлэх | Улсын төсөв | Тоо | 6 төрлийн 22324 мэдээллээр үйлчилсэн | 9 төрлийн 22350 мэдээллээр үйлчлэх | 9 төрлийн урьдчилсан мэдээ: нарийвчилсан мэдээ 181, хоногийн мэдээ 181, 5 хоногийн мэдээ 181, 7 хоногийн мэдээ 26, сарын мэдээ 6, улирлын төлөв 3, анхааруулга мэдээ 61, сэрэмжлүүлэх мэдээ 11, зориулсан мэдээ 23, нийт 673 мэдээ<br>3 төрлийн тойм: хоногийн тойм 181, 7 хоногийн тойм 26, түймрийн эрсдэлийн мэдээ 63 нийт 270 тойм<br>Эхний хагас жилд нийт **943** бүтээгдэхүүн гаргаж, үйлчилгээний 6 төрлийн сувгийг ашиглан **8914** давтамжтай мэдээллээр үйлчилсэн | 100% |
| 61 | Багцын мессежээр анхааруулах, сэрэмжүүлэх, урьдчилан сэргийлэх мэдээгээр үйлчлэх | Улсын төсөв | Тоо | 3 төрлийн 64 мэдээгээр үйлчилсэн | нөхцөл бүрдсэн үед үйлчлэх | ЦА-ын сэрэмжлүүлэх болон анхааруулах 10 мэдээг аймаг, сумдын удирдлага (10), Онцгой комиссын гишүүд (90), малчдын бүлгийн төлөөлөл (125) нийт 225 хэрэглэгчид 2250 мессежээр мэдээ илгээсэн. | 100% |
| 62 | ХААЦУ-ын тойм, зөвлөмж, урьдчилсан мэдээллээр үйлчлэх | Улсын төсөв | Тоо, чанар | Урьдчилсан мэдээний таарц 98.4, 41 тойм, зөвлөмжөөр үйлчилсэн. | Мэдээ, тойм, зөвлөмж-өөр үйлчлэх | 1. Урьдчилсан мэдээ: хөрс гэсэх хугацаа, хаврын хөрсний угтвар чийг тодорхойлох, буудайн бутлалт, голлолтын үе шат илрэх хугацааны 3 мэдээ<br>Зөвлөмж: мал төллөх үеийн, хаврын тариалалтын үеийн 2 зөвлөмж нийт 5<br>2. Дээрх мэдээ, зөвлөмжийг http://www.darkhan-uul.weather.gov.mn сайт, Дархан-Уул аймгийн Ус цаг уур, орчны мэдээ мэдээлэл facebook пэйж хуудаст байршуулж хэрэглэгчдэд үйлчилж байна. аймгийн ОБГазар, ХХААГазар, сумдын ЗДТГазарт мэйл хаягаар цахим илгээсэн. | 100% |
| 63 | Тусгай хэрэгцээний болон бодит мэдээллээр үйлчлэх | Улсын төсөв | Тоо | 40 иргэн, ААНБ-д үйлчилсэн. | Мэдээгээр үйлчлэх | 2026 оны эхний хагас жилийн байдлаар шинжилгээний архивын 01 дүгээр хөмрөгийн баримтыг ашиглан 5 ААНБ, 4 иргэнд үйлчилж нийт 280,000 төгрөгний орлого бүрдүүлсэн.<br>5 дугаар сараас Төрийн үйлчилгээний хүсэлтийн бүртгэл хяналтын системийг нэвтрүүлж иргэнд https://service.e-mongolia.mn, ААНБ-уудад https://les.e-business.mn/ линкээр нэвтэрч 2 иргэнд цаг агаарын тодорхойлолтоор үйлчилсэн. | 100% |
| 64 | Орчны хяналт шинжилгээ, мэдээ, мэдээллээр үйлчлэх | Улсын төсөв | Тоо | 45 ААНБ-аас нийт 474 дээж | Шинжилгээ, мэдээллээр үйлчлэх | Төвийн хамтран ажиллах гэрээтэй ААН-д үйлчлэх 2026 оны орчны хяналт шинжилгээний ажлын хуваарийн дагуу 7 ААНБ-ын үйлдвэрлэлийн орчинд агаарын 31 сорьц, усны 33 дээж, хөрсний 26 дээжид шинжилгээ хийгдсэн. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | авч үйлчилсэн. | | ✓ Агаарын шинжилгээгээр уурын зуухтай байгууллагын тоос тоосонцрын агууламж MNS4585:2025 стандартаас 1.2-2.0 дахин давсан.<br>✓ Хаягдал усны химийн шинжилгээгээр Дархан төмөрлөгийн үйлдвэр ТӨХК, Элемент медикал ХХК-ийн үйлдвэрлэлийн хаягдал усны 3 үзүүлэлтийн бохирдлын агууламж MNS4943:2015 стандартаас 1.3-23 дахин давсан. Бусад сроьц, дээжүүдэд хийгдсэн шинжилгээгээр MNS стандартын зөвшөөрөгдөх хэмжээнд байна.<br>✓ Төвийн төрийн эрдэм шинжилгээ судалгааны байгууллагын үйлчилгээний ажлын орлого 5.6 сая төгрөг төвлөрүүлсэн.<br>Хэрэгжилт 100% | |

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ЕРӨНХИЙ ТЕХНОЛОГИЧ ИНЖЕНЕР Б.САЙНЖАРГАЛ

ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН М.АЛИМАА

# Certificate of Completion

This certifies that

*SUKHBAATAR ALTANDOLGION*

Director,
Center for Hydrometeorology and Environmental Monitoring
of Darkhan-Uul aimag

Has successfully completed

***2026 Invitational Training Program***
***for the Establishment of ICT-Based Integrated***
***Air Quality Monitoring System in Mongolia***
organized by the Korea Environment Corporation.

April 12th ~ 18th, 2026
Seoul, Republic of Korea

Korea Environment Corporation
Chairperson

**LIM, SANG JUN**

Ministry of Climate, Energy and Environment

Eco Harmonist
Korea Environment Corporation



Овог нэр: **С.Алтандолгион**
Регистрийн дугаар: **ТЗ68110167**
Үнэлгээ: Онол: **86**
Ур чадвар: **83.3**

| Хичээлийн сэдэв | Хичээлийн цаг | | | |
|---|---|---|---|---|
| | нийт | лекц | семинар | дадлага |
| 1. ХАБЭА-н удиртгал хичээл | 8 | 8 | - | - |
| 2. Хөдөлмөрийн аюулгүй байдлын үндэс | 30 | 16 | 8 | 6 |
| 3. Хөдөлмөрийн эрүүл мэндийн үндэс | 24 | 18 | 4 | 2 |
| 4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдлийн удирдлага | 8 | 6 | 2 | - |
| 5. Хувийн хамгаалах хувцас, хэрэгслийн зохистой хэрэглээ | 8 | 6 | - | 2 |
| 6. Эрсдлийн харилцаа, ХАБЭА-н сургалт | 16 | 8 | 4 | 4 |
| 7. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний бүртгэл, мэдээлэл | 6 | 4 | - | 2 |
| 8. Анхны тусламж, түүний бэлэн байдал | 8 | 4 | 2 | 2 |
| 9. Гамшгаас хамгаалах бэлтгэл, бэлэн байдал, галын аюулгүй ажиллагаа | 4 | 2 | 1 | 1 |
| 10. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн менежментийн тогтолцоо | 12 | 8 | - | 4 |
| **Дүн** | **124** | | | |

Дархан-Уул аймгийн
ҮЭ-ийн холбооны дэргэдэх
ХАБЭА-н сургалтын төв

(Сургалтын байгууллагын нэр)

(Гарын үсэг)

Х.БАТЖАРГАЛ
(Дарга, захирлын нэр)

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
ҮЭ-ИЙН ХОЛБОО

ХАБЭА
СУРГАЛТЫН ТӨВ

# СЕРТИФИКАТ

№ 2026/01

Сухбаатар овогтой Алтандолгион нь

**"Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн ажилтан бэлтгэх сургалт"**-нд суралцаж төгссөн тул **СЕРТИФИКАТ** олгов.

Сургалтын байгууллагын нэр: **Дархан-Уул аймгийн ҮЭ-ийн холбооны дэргэдэх ХАБЭА-н сургалтын төв**
Эрхийн гэрчилгээний дугаар: **24103004**
Суралцан төгссөн огноо: **2026.02.14**

ХАБЭА СУРГАЛТЫН ТӨВИЙН ЗАХИРАЛ

Х.БАТЖАРГАЛ

Олгосон огноо
2026 он 02 сар 27 өдөр

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*8 дугаар хавсралт*

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН**
**УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ДАРГА**
**С.АЛТАНДОЛГИОНЫ 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ,**
**ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ**
**ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Байгууллагын нэр: *Дархан-Уул, Ус цаг уур, орчны шинжилгээний төв*

**1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин | Нийт (70 оноо) |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1. | 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 64 арга хэмжээний хэрэгжилт | 94.8 | **66.4** |

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Төсвийн төвлөрүүлэн захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|---|
| 1. | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан бэлтгэх 124 цагийн сургалт | 100% | |
| 2 | Монголд МХХТ-д суурилсан агаарын чанарын хяналтын нэгдсэн системийг бий болгох сургалт- БНСУлс | 100% | |
| **Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо** | | | |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ**

| Д/д | Үзүүлэлт | Төсвийн төвлөрүүлэн захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|
| 1. | Хандлага, ёс зүй | |
| 2. | Удирдан зохион байгуулах | |
| 3. | Асуудал шийдвэрлэх | |
| 4. | Манлайлах | |
| 5. | Багаар ажиллах | |
| 6. | Харилцаа | |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 1. | |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 2. | |
| 9. | Мэргэжлийн ур чадвар 3. | |
| **Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо** | | |

4. **Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт<br>*(Төвийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт)* | **66.4** |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт<br>*(Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үнэлгээ )* | |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ<br>*(Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үнэлгээ )* | |
| 4. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт<br>*(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | |
| **Нийт оноо =**<br>( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо | | |

***Үнэлгээ өгсөн:*** ***Төсвийн төвлөрүүлэн захирагч***

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА ............................................ / Э.БАТТУЛГА /

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(овог, нэр)*

.............................. *(огноо)*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***Төсвийн шууд захирагч***

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ДАРГА ........................................ / С.АЛТАНДОЛГИОН /

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(овог нэр)*

.............................. *(огноо)*

4. **Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт<br>*(Төвийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт)* | **66.4** |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт<br>*(Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үнэлгээ )* | |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ<br>*(Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үнэлгээ )* | |
| 4. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт<br>*(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | |
| **Нийт оноо** =<br>( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо | | |

***Үнэлгээ өгсөн:*** ***Төсвийн төвлөрүүлэн захирагч***

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА ............................................ / Э.БАТТУЛГА /

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(овог, нэр)*

.............................. *(огноо)*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***Төсвийн шууд захирагч***

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ДАРГА ............................................ / С.АЛТАНДОЛГИОН /

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(овог нэр)*

2026.06.10 *(огноо)*